

МАХН-ын улс төрийн өөрийн ойлголтын тухайд

Доктор Удо Б. Баркманн

МУИС-ийн зочин профессор, ШУА-ийн ОУСХ,

Монголын "Герман Судлал" Төвийн гүйцэтгэх захирал

МАХН бол урт удаан түүхтэй улс төрийн нам бөгөөд түүний түүхэн уламжлалыг олон өнцгөөс үнэлж дүгнэх шаардлагатай. Анх 1920-оод оны үед Гадаад Монгол улс үндэсний тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж байсан нөхцөл байдлын дор МАХН-ын үндэс суурь эхлэн тавигдсан ба үүнээс нэг жилийн хойно 1921 онд МАХН нэртэй албан ёсны улс төрийн нам болон байгуулагдсан байна.

Анх байгуулагдаж байсан тухайн цаг үед энэ нам агуулгын хувьд үнэхээр Ардын нам мөн байсан юм. Өөрөөр хэлбэл энэ намын эгнээнд монгол улсын нийгмийн бүхий л давхаргыг бүрдүүлж байсан тайж язгууртнууд, лам хуваргууд, цэрэг армийнхан болон малчдын төлөөлөл багтан орсон байжээ. Үзэл бодол, хүсэл сонирхлоороо ялгаатай хэдий ч тэднийг нэгтгэн холбож байсан гол хүчин зүйл бол тэдний тусгаар тогтнолоо гэсэн үндэсний үзэл байлаа. Үндэс угсаагаа хамгаалан авч үлдэх, энэ утгаараа ч монгол үндэстний цаашдын хөгжил дэвшлийн баталгаа болох учиртай тусгаар тогтносон үндэсний Монгол улсаа байгуулах хүсэл эрмэлзэл энэхүү үндэсний үзлийг ивээн тэтгэж байсан билээ. МАХН-ын анхны гишүүд өргөсөн тангарагтаа энэхүү эрхэм зорилгоо тусгаж өгсөн байдгийг дурьдвал: "Шашин үндсэнд харшлах харгис дайсныг цэвэрлэж, алдагдсан эрхийг эгүүлэн аваад, төр шашныг үнэн сэтгэлээр бататган мандуулж, үндэс язгуурыг алдагдахгүй сахих ба дотоод засгийг үнэн сэтгэлээр сайжруулан засамжилж, ядуу дорд ард түмний тусыг туйлаар бодох ба өөрийн дотоод эрхийг өнө үүрд сахиж, дарлах дарлагдахыг зовлонгүй аж төрөхийг чухал болгоно."¹ Монголын үндэсний улсыг эмхлэн байгуулах явдлыг анхнаасаа л нийгмийн асуудалтай уялдуулан авч үзсэн байдаг нь МАХН-ын зохион байгуулалт ба үзэл суртлын талаар зөвлөх үүрэг хүлээсэн оросын коммунист нам, коминтернийн нөлөөтэй холбоотой гэдэг нь эргэлзээгүй. 1920 он гэхэд коминтернийн Алс дорнодын салбарт хэдийнээ Монгол-

¹ Намын хүмүүсийн дагаж явах тангаргийн бичиг, Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд (1920-1960 он), Нэгдүгээр дэвтэр, УБ 1966, 7-р тал.

Төндийн асуудал эрхэлсэн хэлтэс нээгдэн ажиллаж байснаас дүгнэхэд энэ байгууллага Монгол орныг өөрийн хэтийн стратегийн хүрээнд татан оролцуулсан байсныг илтгэнэ.

1921 оны 3-р сард хуралдсан намыг албан ёсоор үүсгэн байгуулах Их Хурал дээр МАХН-аас гадаад монголын иргэдэд хандан уриалга гаргасан уриалга нь тухайн намын анхны хөтөлбөр болсон бөгөөд түүндээ тус намын зорилгыг тодорхойлсон байна. Үүнд:

"Нэгдүгээр. Монгол олон аймгийн ард амьтны эрх мэдлийг мандуулан, дарлал боолчлолын зүйлийг устган, түмэн ардын гашуун зоолонг арилгаад, энх төвшнөөр аж төрөн, бусад олон үндсэн улсын адил аливаа эрх чадал, эрдэм билэг юүгээн бадруулан гэгээрүүлж, улам улам боловсрон хэн тэгш жаргацгаахыг хүснэ.

Хоёрдугаарт. Монголын түмэн ард энх төвшин агаад боловсон олон улсын соёл эрдмийг хүртэж урагш давших эсэх нь монгол үндэстэн өөртөө эзэрхэн нэгэн гэр улс байгуулж, өөрөө засахад буй болой. Хэрхэвч бусад харь үндэсний эзэрхэг түрэмгийгээр мушгин талхигдахад бус болой. Тийм тул манай Монгол ардын намын эрмэлзэх нь: Алсдаа монгол үндэстэн бүгдээр нийлж нэгэн улс болохыг хүснэ. Одоо даруй хятадын харгис мэдлээс ангижирч, сая мөхсөн автономит Гадаад Монголын төрийг дахин шинэчлэн босгохыг зорино...

Дөрөвдүгээр. Монголын олон ардын эрх мэдлийг эрхэмнэх, монголын төрийг босгох хэмээсэн энэхүү хоёр зүйлийн хэргийг бүрэн бүтэн гүйцэтгэхэд манай Ардын Намаас цаг үеийг үзэж, бошгийг халах намын бат журмаар үйлдэнэ."²

Намын энэхүү эрхэм зорилго монголын ард түмний бүхий л анги давхаргын санааг бүрэн дүүрэн илэрхийлж чадсан юм. Ард түмнээсээ үнэхээр үндэслэн урган гарч чадсан, иймээс ч ард түмэнтэйгээ үнэхээр үзэл бодол нэгтэй байсан тэрхүү нөхцөл байдал, мөн Зөвлөлт Орос улсын цэрэг зэвсгийн ба эд материалын дэмжлэг туслалцаа нь МАН-ыг 1921 оны удирдан жолоодогч, зохион байгуулагч улс төрийн хүчин болгож чадсан төдийгүй энэхүү цаг үеийг монголын түүхийн эх сурвалжуудад "Монгол ардын хувьсгал" хэмээн нэрийдсэн байдаг. Шилжилтийн цаг үе болох 1921 оны 3 сарын 13-ны өдөр Монголын Түр Засгийн Газар байгуулагдсан байна. Энэхүү засгийн газрын гүйцэтгэсэн түүхэн үүрэг нь Орос орноос нэвтрэн орж ирсэн цагаан цэргийн анги нэгтгэлүүдийн

² *Монгол Ардын Намаас Гадаад Монголын түмэнд тунхаглан зарлах бичиг, Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд (1920-1960 он), Нэгдүгээр дэвтэр, УБ 1966, 34, 35-р тал.*

эсрэг хийх тулалдааныг удирдан зохион байгуулж, хожим нь Гадаад Монголын Засгийн газрыг эмхлэн байгуулсан явдал байжээ.

Монгол Ардын Нам, түүний тэргүүлэх гишүүд нь оросуудын тусламжтайгаар шинээр үүсэн байгуулагдаж байгаа төрийн өндөр албан тушаалуудыг авч чадсан ба намын үйл ажиллагаа нэн тэргүүнд Нийслэл хүрээнд (өнөөгийн Улаанбаатар) төвлөрч байлаа. Нийслэл хүрээнд орших намын төв байгууллагаас удирдан зохион байгуулснаар Гадаад Монголын бүхий л нутаг дэвсгэр дээр намын салбар үүрүүдийг эмхлэн байгуулж чадсан болно. МАН-ын гишүүдийн тоо эрс өссөн баримтыг харж болно:

МАН / МАХН-ын гишүүдийн тоо (1921–1924)³

Он	1921	1922	1923	1924
Гишүүд/Орлогчид (нийт)	225	769	2.560	4.639

Гэвч Зөвлөлт Оросын зүгээс явуулсан намыг улам бүр үзэл сурталжуулах бодлогын харгайгаар тун удалгүй тайж угсаатнууд, лам хуврагуудыг “ардын дайсан” нэр зүүн намын эгнээнээс хасан зайлуулж эхэллээ. Түшээт Хан аймгийн жишээн дээр энэхүү бодлогын үр дүнд 1921 онд малчин ардууд намын гишүүдийн 80,4%, тайж угсаатнууд 19,6%-ийг бүрдүүлж байсан бол нэг жилийн хойно малчин ардын тоо 87,7% болон өссөн бол тайж угсаатай гишүүдийн тоо 12,3% болон буурсан байдаг.⁴

МАН нь энэ үед намын хөтөлбөрийнхөө дагуу өөрийгээ элитүүдийн буюу нийгмийн сонгомол хэсгийн нам хэмээн үздэггүй байсан юм. Тэр бүү хэл намын анхны хөтөлбөрт тодорхой нөхцлийн дор өөр үзэл баримлалтай улс төрийн намуудтай эвсэл байгуулж болох санааг дэвшүүлсэн байдаг. Эдгээр нөхцөлийг дурьдвал: 1. Монгол үндэстний улсыг үүсгэн байгуулах ба түүнийг хамгаалан авч үлдэх зорилготой намууд, 2. Ард түмний засаглалыг хөхүүлэн дэмжих зорилготой намуудтай МАН хамтран ажиллахад бэлэн хэмээсэн байдаг. Гэсэн хэдий ч МАН тухайн цаг үеийнхээ цор ганц зохион байгуулалт бүхий улс төрийн хүчин хэвээр үлдэв. Тайж язгууртнууд ч, лам хуваргууд ч улс төрийн ямар нэгэн зохион байгуулалттай бүтцэд орж чадсангүй (өнөөг хүртэл энэ талаар мэдээ баримт байдаггүй). Нэлээд сүүлд эрх мэдэл, хөрөнгө чинээг нь хураах явцад харин эдгээр давхаргууд тодорхой хэмжээнд улс төржсөн хэдий ч олон янзын учир шалтгааны улмаас

³ Мөн адил.

⁴ Д. Дамба, Богд Хаан уулын аймгийн намын байгууллага, УБ 1981, 23-р хуудас.

өөсрдийн сонирхлыг төлөөлөх улс төрийн бүлэглэл зохион байгуулж чаддаггүй юм.

Энэ мэтээр улс төрийн тодорхой үзэл баримтлалтай, МАХН-тай эн зэргэцэх улс төрийн хүчин бий болоогүй хэдий ч тухайн үеийн МАН-ын үзэл баримтлал болох ард түмэн засгийн эрх барих тухай ойлголтыг нийт олноороо талархан хуваалцаж байсан юм. МАН-ын тухайн үеийн үзэл баримтлал ёсоор “ард түмний эрх мэдэл” гэдгийг монголчууд уугуул нутагтаа өөрөө эзэн суух хэмээн ойлгон хүлээж авч байжээ.

Гэтэл “ард түмний засаглал” хэмээх нэр томъёоны МАН-ын анх баримтлан гаргаж ирсэн утга санаа нь тус намын дотор орон ажиллаж байсан оросын коммунист нам ба коминтернийн зөвлөхүүдэд таалагдсангүй. Энэ үзэл баримтлалын талаар намын удирдах зөвлөлийн хуралдаанууд дээр удаа дараа авч хэлэлцсэний улмаас намын дотор улс төрийн хагарал гарч, энэ нь цаашид даамжирсаар МАН-ын дотор зөвлөлтийн үлгэр жишээгээр “намын дайснуудаас намыг цэвэрлэх” удаа дараагийн хэлмэгдүүлэх алхмууд өрнөсөн билээ. Тун ч удалгүй хуралдсан МАН-ын II Их Хурал энэхүү их цэвэрлээгээний удаа дараагийн давалгаануудын эх үндсийг тавьж өгөв.

Энэхүү намын Их Хурал нь “төвлөрсөн удирдлагын ардчилсан зарчим” хэмээх зөвлөлт маягийн намын загвар дээр МАН хэдийнээ түшиглэх болсны нотолгоо гэж үзэж болно. Үнэн хэрэгтээ “төвлөрсөн удирдлагын ардчилсан зарчим” гэдэг нь намын өдөр тутмын практик амьдрал дээр ажиглаад үзэхэд онолын ойлголтоосоо тэс хөндлөн утгыг илтгэдэг байсан нь баримтаар нотлогддог. Намын бүхий л үйл ажиллагаа нь зөвхөн намын удирдах цөм хэмээгч данхайн томорсоор байсан Төв хорооны аппаратын гаргасан удирдлага зааварчилгаа руу л анхаарлаа хандуулах болжээ. Намын удирдлага нь эрх мэдлийг улам бүр өөртөө төвлөрүүлсээр, улмаар зөвхөн өөрөө л өөрийгээ хянаж байх нөхцлийг бүрдүүлж чадсан байдаг. Ингээд намын дангаар ноёрхогч гэрхүү нэгжийн ашиг сонирхлын улмаас намын бие даасан гишүүдийн үг хэлэх, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлан боомилж өгсөн байна.

1924 оны 6-р сарын 7-ны өдөр МАН-аас БНМАУ-ыг үндэслэн байгуулах тухай түүхэн шийдвэр батлан гаргасан явдал билээ. БНМАУ-ыг тунхаглахан зарлахаас ч өмнө 1921 оны 8-р сард хуралдсан МАН-ын III Их хурлаас Монгол улсын хөрөнгөтний бус хөгжлийн замаар замнах шийдвэрийг батлан гаргасан байна. МАН нэрээ сольж МАХН болон өөрчлөгдөв.

1924 оны 11-р сарын 8-26-ны хооронд УИХ-ын анхдугаар чуулган хуралдааны үеэр, мөн 1924 оны 11-р сарын 25-ны өдөр БНМАУ-ыг тунхаглан зарлаж байх тэр цаг мөчид Их хурлын чуулганы танхимд зөвхөн МАХН-ын л гишүүд сууж байжээ. Зөвхөн МАХН-ын гишүүд л төр засгийн бүхий л удирдах албан тушаалыг авах нь тэр намын хувьд мэдээжийн хэрэг болсон байв. МАХН нь өөрийн хөтөлбөрийн гол зорилго болох монголын үндэстний төрт улсыг эмхлэн байгуулж чадсан байлаа. Ингээд МАХН улмаар төрийн нам болон хувирчээ, өөрөөр хэлбэл зөвхөн МАХН-ын тэргүүлэгч гишүүд л төрийн бүхий л удирдах албан тушаалуудыг эзлэн авсан юм. Энэхүү үүсээд байсан нөхцөл байдал нь намын гүйцэтгэх үүрэг, байр суурийг шинээр тодорхойлохыг шаардсан болно.

МАХН-ын IV Их хурлын заалтаар 1925 онд намын 2 дахь мөрийн хөтөлбөрийг батлан гаргав. Энэхүү шинэ мөрийн хөтөлбөрт зааснаар МАХН нь тусгаар тогносон бүрэн эрхт Монгол улсыг байгуулах замд олсон бүхий л ололт амжилтыг бататган хамгаалж, эргэлт буцалтгүй болгон бэхжүүлж, тэдгээрийг "... гадаад, дотоодын дайсан этгээд халдахаар ирвэл өмгөөлөн хамгаалах" үүрэг хүлээлээ. МАХН ингээд "... харъяат улсын шар хар харгисуудын үлдэгдлийг бүрмөсөн устган арилгаж жинхэнэ ардын бүгд найрамдах ёсыг улмаар баталж ардын эрх чөлөөг хүндэтгэн явуулж, жинхэнэ ардуудаас улс төрийн хэрэгт зүтгэлцүүлэх..."⁵ үндсэн зорилтыг өмнөө дэвшүүлэн тавив.

МАХН гэхдээ энэ мөчид улс орноо хөрөнгөтний бус хөгжлийн замаар замнуулах мөрийн хөтөлбөр баталсан хэдий ч түүнийгээ амьдрал дээр бодитойгоор хэргэжүүлж чадахаар мэргэшсэн марксист нам болон бэхжиж хараахан амжаагүй байсан байна. Монгол судлаач О.Латиморын хэлсэнчлэн МАХН нь илүүтэйгээр "марксизмаар далавчилж амжаагүй байсан зүүнтнүүд ба үндэсний үзэлтнүүдийн эвсэл"⁶ шинжийг илтгэж байжээ. Марксизм нь ердөө л ор нэр төдийхэн, уриа лоозонгоос хэтрээгүй байсан нь он жилийн дараа аажмаар өөрчлөгдсөөр ЗХУ-д боловсрол олсон намын ажилтнуудын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр марксист-ленинист үзэл суртал МАХН руу нэвчин орох үүд хаалга дэлгэгдсэн байна. МАХН нь зөвлөлтийн үлгэр жишээг сохроор даган, өөрсдөө ч сайн тайлбарлаж чадаагүй хэрнээ өөрийн эгнээний дотрос "баруунтан ба зүүнтны нугалаатнуудыг" хайн илрүүлж, тэдний эсрэг

⁵ *Монгол Ардын Хувьсгалт Намын мөрийн хөтөлбөр, Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд (1920-1960 он), Нэгдүгээр дэвтэр, УБ 1966, 149-р тал.*

⁶ *О. Латимор, Национализм ба хувьсгал, Лайден 1955, 83-р тал.*

тэмцэл өрнүүлжээ. Эдгээр цэвэрлэгээ нь намын бодлогыг хүчээр тулган хүлээн зөвшөөрүүлэхэд хүргэж, намынхаа гишүүдийг үгий нь сөрөхгүй, дуулгавартай дагадаг сахилга батын зам руу эргэлт буцалтгүй оруулж өгсөн байна.

1929 онд Коминтернийн Алс Дорнодыг хариуцсан хэлтсээс МАХН-ын VII Их Хуралд өгсөн үнэлэлт дүнэлтэндээ Монгол улсад хөрөнгөтний бүс хөгжлийн үе шат амжилттай хэргэжиж дууслаа хэмээсэн байдаг. Түүнчлэн Коминтернийн зүгээс Монгол орны улс төрийн үйл явцын цаашдын өрнөлтийг өөрийн гараар залуурдах шаардлагатай боллоо гэж үзжээ. Коминтерн монголын тайж язгууртнууд ба лам хуврагуудыг улс төрийн ангийн дайсны хувьд устган сөнөөх заавар өглөө. 1929 оны МАХН-ын Төв Хорооны 2-р Бүгд хурлаас тайж язгууртнууд болон сүм хийдүүдийн өмч хөрөнгийг хурааж, хөдөө аж ахуйн хамтралууд байгуулах тогтоол гаргав.

Энэхүү хурлын шийдвэрийг хэргэжүүлэх үйл явц нь аймшигтай үр дагаврыг дагуулсан билээ. Ахархан хугацааны дотор монголын хамгийн чухал баялаг болох малын тоо толгой 7 саяас 16,2 сая хүртэл нэмэгдэн хоргоджээ (1932 оны байдлаар). Хүн амын дотор дургүйцэн эсэргүүцэх хандлага газар авлаа. 30-аад оны эхэн үеэр ялангуяа монголын баруун хязгаарт малчин ардууд, лам нарын хамтарсан бослого хөдөлгөөнүүд нэлээд олон удаа өрнөв. Эдгээр бослого хөдөлгөөнүүд нь ард олон намын бодлогыг үндсэндээ хүлээн зөвшөөрөхгүйгээс шалтгаалсан ажээ. Бослого хөдөлгөөнүүдийг бүгдийг цэрэг зэвсгийн хүчээр нухчин дарсан байна. МАХН ингээд анх дуаа өөрийн ард түмний эсрэг хүч хэрэглэлээ. Энэхүү байдал тус намын бодит байдлыг үнэн зөв үнэлж дүгнэх чадваргүй, түүнчлэн өөрийн алдааг хүлээн зөвшөөрөх ба түүнийгээ засан залруулах тэнхээгүй улс төрийн хүчин болохыг нь тод томруун харуулж өгчээ. Гэхдээ МАХН-ын ийм алхам руу орох болсон жинхэнэ учир шалтгаан нь тухайн үеийн Коминтернийн баримталсан бодлогын үр дагавар, мөн МАХН өөрөө Коминтернийн гар хөлийн үзүүр болсноос шууд шалтгаалсан байдаг.⁷

Энэ үед авч хэргэжүүлсэн тайж язгууртнууд, лам хуврагуудыг улс төр, эдийн засаг, бие сэтгэлийн хувьд мөхөөх бодлогын хор уршиг тухайн цаг үеэсээ халин гарсан гүнзгий хор уршигийг араасаа дагуулсан билээ. Энэхүү харгислал нь монголын нийгэм дэх олон ургальч үзлийг бүрмөсөн устган дарж чадсан байна.

⁷ Монголд социализм байгуулагч Коминтернийн бодлого, Үнэн, 1992.04.23.

30-аад онд МАХН нь ЗХУКН, Коминтерн болон ЗХУ-ын Аюлаас Хамгаалах Байгууллагын аппаратын гарт бүрэн захирагдах болсон. 1937–1940 оны хэлмэгдүүлэлтийн он жилүүдэд МАХН-ын хамгийн шилдэг боловсон хүчин бүхлээрээ хэлмэгдэв.⁸ Тэдгээрийг айлган сүрдүүлж эсэргүүцэх тэнхэлгүй болгох, цагдан хорих, алж устгах зэргээр хэлмэгдүүлсэн байна. Тухайн цаг үед Х.Чойбалсаны гарт улс төрийн бүхий л эрх мэдэл төвлөрсөн хачирхалтай байдал үүсээд байв. МАХН түүнийг маш хүчтэйгээр тахин шүтэх бодлого баримтлав. Х.Чойбалсан ба бусад намын албан тушаалтнууд Москвагаас бүхий л зааварчилгаа, эрх мэдлээр хангагдаж байлаа. Эдгээр намын ажилтнуудын хүчээр бүхий л террорыг МАХН-ын нэрийн өмнөөс гүйцэтгэж иржээ. Гэсэн хэдий ч ард түмэн энэ бүх аллага, хэлмэгдүүлэлтийг МАХН оросуудын дарамт шахалтаар хийж гүйцэтгэж байгааг ойлгож байв. Энэхүү нөхцөл байдлын улмаас иргэд өөрсдөө хэдийгээр гүнзгийгээр зовон шаналж буй ч үйл явцыг наанатай цаантайгаар ойлгон ялган салгах чадвартай байжээ. Харин ч энэхүү террорын цаад учир шалтгааныг ойлгосны улмаас намын гишүүдийн тоо тасралтгүй өсөн нэмэгдэж иржээ:

МАХН-ын гишүүдийн тоо 1934–1940⁹

Он	1934	1935	1936	1937	1938	1939	1940
Гишүүд/орлогч гишүүд	8.018	8.234	9.849	10.218	10.218	13.883	15.774

Террор хэдийгээр учир утаггүй мэт санагдавч, түүнийг санаачлагчдын өдүүлбэр санааг өнөө үед ойлгоход тун ч бэрх хэдий ч, ямар ч атугай хэлмэгдүүлэлтийн он жилүүдийн үр дүнд намын ажилтнууд ба энгийн ард иргэдийг маш чанд сахилга баттай болгон номхруулж дөнгөсөн болно. Ийм нөхцөл байдал бий болчихоод байхад намын удирдлага үзэл суртлын байр сууриа тодорхой илэрхийлэхгүй байсан нь хачирхалтай. 1940 онд МАХН-ын X Их Хурал хуралдаж, төлөөлөгчид намынхаа 3 дахь мөрийн хөтөлбөрийг баталцаав. Энэ мөрийн хөтөлбөрт "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бодлого нь тус орны эдийн засагт байгаа феодалын үлдэгдлүүдийг бүрмөсөн устгаад, хүн ардын мэдрэлд байгаа феодализмын үлдэгдлүүдтэй тэмцэж, улмаар нийгэм журамд орох явдлыг бэлтгэхийн тулд тус орныг капиталын ёсны бус замаар хөгжүүлэх явдлыг хангахад чиглэгдэх"¹⁰ явдал хэмээн

⁸ У. Б. Баркманн, *Монголын түхийн гунигт үе шатны анхны тэмдэглэл-1930-д он, Ази, Африк, Латин Америк*, 1 (1993), 1043-1062-р тал.

⁹ Д. Даш, *МАХН-ын өсөлтийн нийгмийн бааз, Улаанбаатар 1982, 158-р тал*,
¹⁰ *Монгол Ардын Хувьсгалт Намын X Их Хурал, Дэлгэрэнгүй тайлан, Улаанбаатар 1970, 370-р тал.*

маллаа. Өмнө нь МАХН өөрийнхээ дүр зургийг гол нь өмнөө тавьсан жирлгоосоо ургуулан гаргаж ирдэг байсан бол энэ мөрийн хөтөлбөрт МАХН өөрийгээ "... монголын хөдөлмөрчин олны тэргүүний зохион бийгуулалттай, сахилгатай отряд"¹¹ хэмээн анхнаасаа бүх эрх мэдлийг гартаа авснаа ил тодоор зарлан тодорхойлж орхив.

МАХН ингээд ард түмний нам байх гэсэн өөрийн түүхэн үрмэлзлээсээ татгалзлаа. МАХН энэ мөчөөс төрийн ба тэмцлийн "шилмэл" цөөнхийн нам болон хувирч, түүний боловсон хүчин нь зөвхөн өөрийнх нь эгнээнээс төрөн гардгаар барахгүй МАХН-ын өөрийн нь бий болгосон "Намын боловсон хүчин бэлтгэх механизм"-аас байнга нөхөн салбэгдэж байдаг бүлэглэл болон хувирчээ. Энэхүү намын боловсон хүчин хэмээн тооцогдохын тулд тухайн хүн өөрийн "ЗХУ-д хязгааргүй үнэнч" байж чадахаа батлах ёстой, өөрөөр хэлбэл ЗХУ-ын удирдан жолоодох эрх мэдлийг үг дуугүй хүлээн зөвшөөрөх явдал байлаа. Гэсэн хэдий ч МАХН-ын үзэл суртлын байр суурь нэн тодорхой бус байв. МАХН-ын гурав дахь мөрийн хөтөлбөрт ердөө л "Монгол Ардын Хувьсгалт Нам нь сургаалыг гагцхан зөв шинжлэх ухаан гэж батлан үзэж өөрийн ажилд удирдлага болгон явуулж, монголын ард түмний тэмцлийг чиглүүлнэ."¹² Харин энэ мөрийн хөтөлбөрт ямар онол сургаалийг нэрийдсэн нь тодорхойгүй бөгөөд хэдийгээр мөрийн хөтөлбөрийн төгсгөл хэсэгт "Маркс, Энгельс, Ленин, Сталины сургаал" хэмээн оруулж өгсөн ч энэ нь санаатайгаар татгалзсан хэрэг бололтой.

МАХН-ын гуравдахь мөрийн хөтөлбөрт БНМАУ-ын хэтийн хөгжлийн замыг урьдчилан зааж өгчээ. Үүнтэй уялдуулан 1940 оны 6-р сарын 30-ны өдөр Их хурлын төлөөлөгчид БНМАУ-ын хоёр дахь Үндсэн хуулийг батлан гаргалаа. Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд монголын нийгмийн хөгжлийн тухай оруулсан заалтад: "Нэгдүгээр зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол эзэрхэг түрэмгийг ба феодалын дарлалыг устгасан цаашид нийгэм журамд давшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин (малчин, ажилчин, оюутан) ардын тусгаар тогтносон улс мөн болно."¹³

БНМАУ-ын улс төрийн бодлогын хувьд "Гадаад Монголын бүрэн эрхт байдлыг" 1945 оны Ялтын Бага хурлын үеэр Их гүрнүүд хүлээн зөвшөөрсөн явдал нэн чухал алхам байлаа. Их Британи, АНУ, ЗХУ нь

¹¹ Мөн адил, 371-р тал.

¹² Мөн адил, 371-р тал.

¹³ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль (1940 он, монгол шинэ үсгээр), Монгол Улсын Үндсэн хууль, Баримт бичиг, Улаанбаатар 2004, 141-р тал.

ошиж байгаа мэт харагдавч мэдээжээр нам эрх араа давамгайлах болжээ. МАХН нь өөрийгөө анлайлагч хэмээн ойлгох болсноор нийгэмд дан кийг өөртөө олгосны үр дүнд төрийн аливаа нэгэн югдох үндсэн шалгуур нь энэхүү намын гишүүн их хэмжээнд хүрч очсон байна. ЗХУКН нь Монгол сан удирдах төвшний бүхий л албадыг алхам хянан шалгаж, өөрийн асар хүчтэй нөлөөг огтхон х байсны улмаас ЗХУКН-тай зөвшилцөхгүйгээр жааг өчүүхэн төдий ч засварлан сайжруулах

үндэсийг тавих"-ын тулд МАХН-ын байгуулах нийгэмд үйлдвэрлэлийн хэрэгслийг бүх нийтийн юв. Энэхүү төлөвлөгөөг гол нь хөдөө аж ахуйн болсны учир нь шинээр үүссэн аж үйлдвэрийн "улсын социалист өмч" байсантай холбоотой. салбар тухайн цаг үед ач холбогдол багатай д нэгдэлжүүлэх ажлыг 1950-иад оны үед мал аж дэн үе шаттайгаар хэргэжүүлсэн байна. Зарим үйтэж, сөрөг үр дагавар авчирсан хэдий ч МАХН ийг маш том амжилт байсан хэмээн тунхаглав. ийн хөтөлбөрт энэ талаар дурдахдаа: "Ардын аж жлыг амжилттай дуусгаснаар эдийн засгийн олон рилгаж, улс ардын аж ахуйн нэгдсэн социалист

ол орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн оров. Эдийн засаг, соёлыг хөгжүүлэх таван й тайланд тусгагдсан тоон илэрхийлэлүүд нь ин засгийн салбарын хөгжлийн үзүүлэлт төдийгүй ХТЗ-ийн гишүүн орнуудтай хамтын ажиллагааны суурь болж өгөв.

цаг үеийг ерөнхийдээ Монгол оронд социалист даа ялсан он жилүүд хэмээн МАХН үнэлсэн байна. эж дүгнэхийн цаад учир шалтгаан нь Улсын Их йгмийн хөгжлийн шинэ үе шатанд таарч тохирсон йловсруулахтай холбоотой байжээ. 1960 оны 7-р йментаас шинэ үндсэн хуулийг батлан гаргалаа. ХН-ын дангаараа удирдан жолоодох эрхийг анх

алт Намын программ, Үнэн, 1966.06.14.

удаа энэхүү үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн юм. Шинэ үндсэн хуулийн оршил хэсэгт: "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог Монгол Ардын Хувьсгалт Нам мөн."¹⁶

1966 оны 6-р сард хуралдсан МАХН-ын XV Их Хурал дээр МАХН-ын дарга Ю. Цэдэнбал Төв Хорооны тайлан илтгэлд Монгол оронд нийгмийн гүн гүнзгий өөрчлөлт гарсныг цохон тэмдэглэв. ЗХУ-ын тусламж дэмжлэгээр үүсэн байгуулагдсан аж үйлдвэрийн салбар энэ хугацаанд монголын үндэсний нийт бүтээгдхүүний хагасаас илүүг үйлдвэрлэн гаргах болжээ. Энэхүү салбарыг дагаад шинээр үндэсний ажилчин анги бүрэлдэн тогтсоноор МАХН-ын гишүүдийн нийгмийн бүтэц ч өөрчлөгдөж эхлэв.

**МАХН-ын гишүүдийн дотор ажилчин ангийн
эзлэх хувийн жин (хувь)¹⁷**

Он	1947	1948	1949	1953	1954	1956	1957	1958	1959	1960
хувь	4,7	5,8	6,8	9,7	14,9	16,0	16,6	19,4	21,2	23,2

МАХН-ын жинхэнэ ба орлогч гишүүд¹⁸

Он	1954	1955	1956	1957	1958	1959	1960
Нийт гишүүд: Жинхэнэ ба орлогч	31.774	34.884	39.144	42.896	44.124	44.434	43.725

1961 оны МАХН-ын XIV Их Хурлаас түүний тэргүүлэгч гишүүд Монгол оронд "социализмыг бүрэн төгс байгуулж дуусгах" хөгжлийн үе шатны мөрийн хөтөлбөр боловсруулах шийдвэр гаргасан байдаг. Намын дөрөв дэх мөрийн хөтөлбөрийг 1966 оны МАХН-ын XV Их Хурал дээр батлав. МАХН нийгэм-эдийн засгийн хөгжлийн дараагийн үе шатан дахь өөрийн гүйцэтгэх үүргийг ингэж тодорхойллоо: "... Бүгд Найрамдах Монгол Ард Улсад социализм байгуулж дуусгах үед Монгол Ардын Хувьсгалт Намаас тавих гол зорилт бол орчин үеийн шинжлэх

¹⁶ Монгол Улсын Үндсэн хууль, Баримт бичиг, Улаанбаатар 2004, 247-р тал.

¹⁷ Д. Даш, МАХН-ын өсөлтийн нийгмийн бааз, Улаанбаатар 1982, 234-р тал.

¹⁸ Мөн адил.

уулан-техникийн дэвшлийн ололтыг үндэс болгож социалист нийгмийн үйлдвэрлэх хүчнийг бүхий л талаар хөгжүүлэх, тус орны эдийн засгийн хүч чадал, социалист соёлыг түргэн хурдацтай өрнүүлэх, нийгмийн социалист харилцааг боловсронгуй болгох, хөдөлмөрчдийг коммунист ёсоор хүмүүжүүлэх ажлыг хүчтэй болгох, улмаар ард түмний аж амьдралын байдал, соёлын хэмжээг цаашид дээшлүүлэх явдал мөн.¹⁹

Намын гурав дахь мөрийн хөтөлбөртэй харьцуулж үзвэл МАХН-ын улс төрийн талаархи өөрийн хөрөг зураг үндсээрээ өөрчлөгсөн нь ойлгогдож байна. МАХН нь шинэ мөрийн хөтөлбөрийнхөө дагуу өөрийгээ "монголын ард түмний марксист-ленинист манлайлагч" хэмээн томъёолох болжээ. Өөрөөр хэлбэл МАХН нь ЗХУКН-ын улс төр-үзэл суртлын байр суурийг баримтлах болсноо ил тодоор зарлалаа гэсэн үг. МАХН нь "намын амьдралын ленинист дэг жаягийг" намынхаа дотоод амьдралын баримтлах үндсэн зарчим болгон тунхаглав. Үнэн хэрэгтээ энэхүү зарчим нь намын өдөр тутмын амьдралд ор нэр төдийхэн л үйл байв. МАХН-ын эрх мэдлийг гартаа атгасан тэрхүү төв аппарат нь хэнд ч нэвтэршгүй өөрийн гэсэн тоглоомын дүрэмтэй болсон бөгөөд арын хаалга, танил тал, нутаг нугын үзэл зэрэг сөрөг үзэгдэлд улам бүр идэгдсээр байжээ. МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга, мөн МАХН-ын Улс төрийн товчоо нь хэмжээлшгүй ноёрхлоо тогтоож, ямар ч ардчилсан хорооны үгийг хүлээн авахааргүй эрх тархтай болж чадлаа. МАХН-ын удирдагчдын эрх барих үйл ажиллагааг зөвхөн ЗХУКН л хязгаарлаж чаддаг байсан бөгөөд тэрбээр монголын нийгмийн амьдралын бүхий л хүрээн дэх МАХН-ын үйл ажиллагааны хүрээ хязгаар, орон зайг зааварлаж өгдөг байв.

БНМАУ энэ хугацаанд өөрийнхөө хэрээр эдийн засгийн мэдэгдэхүйц ахиц дэвшилд хүрээд байлаа. 1962 онд БНМАУ-ыг ЭЗХТЗ (Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл)-ийн гишүүн орноор элсэн орсноор энэхүү хөгжлийн эрч хүч улам далайцтай болж чадсан. Ялангуяа "ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх, социалист эдийн засгийн интеграцийг хэргэжүүлэх" хөтөлбөрийн хэргэжилт нь монголын эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой алхам болж өгсөн. Энэ хөтөлбөрийн хүрээнд аж үйлдвэржилтийн үйл явцыг хөгжүүлэн тэлэх, аж үйлдвэрийн салбарт бүтцийн өөрчлөлт хийх, хөдөө аж ахуйн салбарыг механикжуулах зэрэг алхмууд хийгдсэн байна. Монгол улс энэ хугацаанд зөвхөн ЗХУ-аас бус, харин бусад социалист орнуудаас ч мөн адил хэмжээгээр хамааралтай болж ирсэн. Эрүүл мэндийн салбар, боловсролын систем, нийгмийн

¹⁹ МАХН-ын программ, Үнэн, 1966.06.14.

халамжийн зэрэг салбаруудын хөгжлийг анх БНМАУ-ыг эмхлэн байгуулж байсан гарааны нөхцөл байдал, цаг үетэй харьцуулахад үнэхээр үсрэнгүй ахиц дэвшилд хүрч чадав. Гэхдээ энэхүү хөгжил дэвшилд хүргэсэн нөөц бололцооны эх үүсвэр нь үндсэндээ ЗХУ болон бусад социалист орноос зээл тусламжаас орж ирсэн санхүүжилт байлаа. ЗХУ, ЭЗХТЗ болон бусад социалист орнуудад төлөх ёстой он удаан жил хуримтлагдсан хуучин өр төлбөрийг хүчингүй болгуулах, ахин шинээр зээл авах явдал монголын улс төрчдийн хувьд хэвшмэл практик болж хувирсан байлаа. БНМАУ нь эдийн засгийн энэхүү харилцааныхаа хүчээр амиа зогоож ирлээ. Өнөөгийн шинэ Монгол улсаас хуучин ЗХУ-ын хууль ёсны залгамжлагч ОХУ-д төлөх ёстой уул овоо мэт их өр ширний асуудал хоёр орны харилцаанд асуудал болон босч ирсэн нь энэхүү социализмын үеийн монголын засгийн газрын баримталж ирсэн бодлогоос үүдсэн шууд үр дагавар мөн.²⁰

МАХН-ын хэргэжүүлж ирсэн бодлого нь монгол амьдралын хэв маягийг улам бүр хөшүүн, хүнд суртлын хэвэнд цутгасаар, иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлан боосоор ирсэн хэдий ч энэ улсын нийгэм нь өнгөрсөн зууны түүхтэй харьцуулахад илүү иргэншин соёлжиж чадсан нь гайхалтай. Намын төв аппарат эрх мэдлээ хэтрүүлж байсан явдлыг жишээ нь 30, 40-өөд оны дур зоргоороо авирлаж байсан тэрхүү цаг үетэй харьцуулах аргагүй болжээ. Энэхүү өөрчлөлт нь гэхдээ монголын ард иргэдийн улс төрөөс хэт дайжих, нийгмийн хөгжлийг огт сонирхохгүй идэвхгүй болох, зөвхөн амин хувийн амьдралаа л сонирхох, өдөр тутмын ажилдаа дур сонирхолгүй болох, хүрээлэн буй нийгмийн орчин нь таалагдахгүй бухимдах, улс төрөөс хөндийрэх, хувь заяаны гутранги үзэл зэрэг сөрөг үзэгдлийг улам бүр дэвэргэсээр байлаа. Гэхдээ монголын иргэд хүсэн хүлээж байсан тэрхүү амьдралынхаа төвшинг хангаж чадахаар эдийн засгийн нөөц бололцоог өөрсдийнхээ хөлс хүчээр бүтээж чадаагүй гэдгийг бас харгалзаж үзэх ёстой болов уу.

Ордны хуйвалдаан

Л.И.Брежнев нас нөгчсөнөөс хойш 1992 оны 11-р сарын 10-ны өдөр ардаа маш хүчтэй нөмөр нөөлөг бүхий улс төрч Ю.В.Андропов түүний халааг залгамжлан ЗХУКН-ын ерөнхий нарийн бичгийн дарга болов. Андропов 1967 оны 5-р сараас эхлэн ЗХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Нийгмийг Аюулаас Хамгаалах Хорооны даргаар ажиллаж ирсэн нэгэн байв. Тухайн үеийн ЗХУ-ын дотоод дахь зөрчилдөөн

²⁰ У. Б. Баркманн 1989-1993 оны хоорондох цаг үеийн Монгол – ЗСБНУ/Оросын харилцааны тухай”, *Asien-Deutsche Zeitschrift fuer Politik, Wirtschaft und Kultur* 3(1995), 22-40-р мал.

хямралыг түүнээс илүү ойлгох хүн байхгүй гэхэд хилсдэхгүй. Андропов гарч ирснээр ЗХУКН-ын баримтлах бодлого эрс хувьсан солигдож эхэлсэн түүхтэй. Намын ягширмал, хөшүүн ялзарсан бодлогыг эвдэн өөрчилж эхэллээ. Алдаа завхарлыг ил тодоор зарлаж, тэдгээрийг захаас нь эхлэн залруулах арга хэмжээнүүд авч, зөвлөлтийн нийгмийг энэхүү гүнзгий хямралаас хэрхэн гарах арга замыг анх удаа олон нийтэд нээлттэйгээр хамтран хайж эхэллээ. Андропов ЗХУКН-ын хүрээллийн доторхи эрх мэдлийн бүхий л шат дамжлагад буглаад байсан хамаатан садан, танил талын гэсэн “арын хаалганы” сүлжээг цэвэрлэх ажлаар гараагаа эхэлсэн байна.

ЗХУКН-ын хүрээнд явагдаж эхэлсэн энэхүү шинэ бодлого МАХН-ыг хүссэн хүсээгүй доргиож эхэллээ. Гэхдээ эхний ээлжинд Улс Төрийн Товчооны цөөн хэдхэн хүнийг халж солих хүрээгээр хязгаарлагдав. Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайд асан Б.Дэжидийг Улс Төрийн Товчооны орлогч гишүүнээс жинхэнэ гишүүнд, Ц.Намсрайг МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн даргын албан тушаалд сонгосон нь тухайн үеийн хамгийн чухал өөрчлөлтүүд болно. 1940 оноос хойш намын даргын албыг хашиж байгаа ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын эрх мэдэл халдашгүй дархан хэвээрээ байлаа. Гэхдээ л түүний байр суурь намынхаа дотор ганхаж эхэлжээ. Нэг талаас түүний он удаан жилийн дотны нөхөр Л.И.Брежнев насан эцэслэснээр түүнд ЗХУКН-ын удирдлагатай шууд харьцдаг байсан тэр боломж хаагдсан, нөгөө талаас түүний орос эхнэр, эрх мэдэлд хэт шунасан, биеэ тоосон улс төрийн хов хутгагч А.И.Цэдэнбал-Филатовагийн зан араншин, үйлдлүүдэд дургүйцсээр ирсэн Улс Төрийн Товчооны гишүүд түүний эсрэг ил тодоор эсэргүүцлээ илэрхийлэх болов. Эсэргүүцэгчдийн эгнээнийхэн намын удирдлагын шинээр сонгогдсон гишүүд болох Б.Дэжид, Ц.Намсрай нарыг тойрон хүрээлж эхлэв. Энэ бүлгийг ЗХУ-ын элчин сайд С.П.Павлов, БНМАУ-ын Нийгмийг Аюулаас Хамгаалах Яаман дээр ЗХУ-ын аюулаас хамгаалахын төлөөлөгч В.К.Радченко нар түшин дэмжиж байсан юм.

1984 оны 8-сарын 24-ний өдрийн дугаараараа монголын өдөр тутмын хэвлэл, тэр үеийн МАХН, Засгийн газрын төв хэвлэл “Үнэн” сонин өмнөх өдөр нь хуралдсан МАХН-ын Төв Хорооны Онц Бүгд хурлын тухай нэгэн хачирхалтай мэдээг олон нийтэд хүргэсэн байна. Энэ тухай товчхон мэдээлснийг дурдвал: “... Бүгд Хурал нөхөр Юмжаагийн Цэдэнбалыг биеийн эрүүл мэндийн байдлыг нь харгалзан үзэж, өөрийн нь зөвшөөрснөөр МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажил, МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүнээс чөлөөлөв... Нөхөр Ю.Цэдэнбал Монгол Ардын Хувьсгалт

Нам, социалист төрийг 40 гаруй жилийн турш удирдахдаа БНМАУ-д социализм байгуулах үйл хэрэгт өөрийн бүхий л оюун билэг, авъяас чадвар, хүч чадал, арвин баялаг туршлагаа бүрэн зориулж ирснийг Бүгд Хурал онцлон тэмдэглэжээ... МАХН-ыг үзэл суртал, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, түүний эгнээг нэгтгэн нягтруулах, цэвэр ариун байдлыг нь хангах, нам, ард түмний холбоо, нэгдлийг бататгах, нам, улс төрийн байгууллагын ажлыг улам бүр боловсронгуй болгох талаар нөхөр Ю.Цэдэнбалын явуулсан олон талт үйл ажиллагааг Бүгд Хурал өндөр үнэлэв."²¹

Ю.Цэдэнбалыг эрх мэдэл, албан тушаалаас нь зайлуулснаар МАХН-ын Улс Төрийн Товчоо, засгийн газрын дотро боловсон хүчний халаа сэлгээ эхэлсэн байна. 1974 оноос эхлэн Сайд нарын Зөвлөлийн даргын албыг хашиж байсан Ж. Батмөнх МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга, Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргын албыг хүлээн авлаа. Ерөнхий нарийн бичгийн дарга өөрийн энэ шинэ албыг хүлээн авсныхаа дараахан нийслэл хотод болсон МАХН-ын төлөөлөгчдийн бага хурал дээр энэ анхныхаа үгийг хэлсэн байна. Тэрбээр хэлсэн үгэндээ намын ажилд гарсан алдаа дутагдлыг хүлээл зөвшөөрч, монголын эдийн засгийн байдалд анх удаа нууж хаахгүй, гоёж гоодоогүй үнэн зөв үнэлгээ дүгнэлтийг өгөв. МАХН өөрийн удирдан чиглүүлэх үүргийг огтхон ч хөндөлгүйгээр ард түмэнтэй анх удаа "харилцан ярилцлага" хийсэн нь энэ.

Монголын өөрчлөн байгуулалт

1985 онд М.С.Горбачев ЗХУКН-ын ерөнхий нарийн бичгийн дарга болоод перестройка-г эхлүүлэх тэр мөчид МАХН-ын удирдлага өөрийн явуулж байгаа шинэ бодлогодоо итгэл дүүрэн болж, улмаар Зөвлөлт дахь өөрчлөн байгуулалтыг арай хожуу боловч зах зухаас нь дуурайлган хийж эхлэв. 1986 оны 3-р сарын 28-аас 31-нийг дуустал хуралдсан МАХН-ын XIX Их Хурлаас монголын өөрчлөн байгуулалтын үндсэн зарчмуудыг тодорхойлон гаргаж баталлаа. Эхний ээлжинд эдийн засгийн салбарыг өөрчлөн байгуулах, эдийн засгийн үйл ажиллагааны үр ашиг, чанарын асуудалд түлхүү анхаарах хэрэгтэй болов. Харин МАХН-ын өөрийгээ "монголын ард түмний марксист-ленинист манлайлан зохион байгуулагч", "монголын ард түмний улс төрийн удирдагч хүчин" хэмээн үзэх үзэл огтхон ч өөрчлөгдөхгүй хэвээр үлдлээ. Мөн түүнчлэн "социализмын материал-техникийн баазыг байгуулах" зорилтыг хадгалан авч үлдээд, марксизм-ленинизмийн, социалист болон пролетарийн

²¹ МАХН-ын Төв Хорооны Ээлжит бус 8.Бүгд Хурлын тухай сонсгол мэдээ, Үнэн, 1984.08.24.

интернационализмийн үндсэн зарчмууд, "ЗХУ-тай хамтран ажиллах интернационалист зарчимдаа" МАХН цаашдаа ч үнэнч хэвээрээ хоцров. МАХН-ын удирдлага өөрийн ажлын арга барилын хэлбэрийг өөрчлөн, өдийн засгийн бодлогыг засаж залруулснаар цаашдаа ч "социализм"-ыг бүтээн байгуулах зорилтоосоо няцаж ухрах шаардлагагүй хэмээн үзэж байжээ. Намын шат давхаргуудаар боловсон хүчний өөрчлөлт нэлээд хийгдсэн хэдий ч намын төв аппарат хэвээрээ оршин тогтносоор байлаа. Өөрөөр хэлбэл хувьсал өөрчлөлт гарах магадлалтай хэдий ч хувьсгалт гүнзгий өөрчлөлт хийгдэхгүй гэдэг нь анхнаасаа л тодорхой байсан байна.

МАХН-ын зүгээс түүхийн сэдвээр өрнүүлсэн мэтгэлцээн нь харин ард түмэнтэй санаа бодлоо уралдуулах анхны жинхэнэ "харилцан ирилцлага" болж чадсан юм. МАХН-ын өдөр тутмын хэвлэл болох Үнэн сонины 1988 оны 11-р сарын 16-ны өдрийн дугаарт "Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг сайжруулах шинэ зорилт" МАХН-ын Улс Төрийн Товчооны тогтоолыг хэвлэн гаргав. Энэхүү тогтоолд цаахдаа: "... Өнөөдөр түүхэн замналаа эргэн харж, үнэн зөв дүгнэлт хийж, зохих сургамж авах явдал намын үзэл суртал-хүмүүжлийн салбарт хийх өөрчлөн байгуулалтад онцгой суурийг эзлэнэ. Монголын ард түмний эрх чөлөөт шинэ амьдралыг зохиохын төлөө тэмцлийг манлайлж, маргашгүй амжилтад хүргэсэн МАХН-ын туулсан зам нарийн төвөгтэй, багагүй бэрхшээлтэй учирч байсан билээ... Манайд гучаад оноос хувьсгалт хууль ёсыг ноцтой завхруулж, улмаар нэг хүнийг, гухайлбал Х.Чойбалсанг тахин шүтэх явдал газар авснаар нам, төр, цэрэг, аж ахуй, соёлын боловсон хүчин, ард иргэд, жирийн лам, хувраг, сүсэгтнийг олноор хэлмэгдүүлж, хувьсгалын эсэргүү хүчний үүр голомт болсон гэдэг нэрээр сүм хийдийг нураан, соёлын өвийг үрэн таран хийсэн гунигт явдал гэрчилнэ... Нам, ард түмний ашиг сонирхолд харш эдгээр үзэгдэл, үйл явдал үүсэн гарсны уг шалтгаан, уршиг холбогдлыг гүнзгий судалж, дахин давтагдахад хүргүүлэхгүй байх хилс гүтгэгдэж хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээх, түүхэнд нам, төрийн боловсон хүчний гүйцэтгэсэн үүрэг, үйл ажиллагааг үнэн бодитой цэгнэн харуулах шаардлага зүй ёсоор гарсан юм."²²

Энэхүү нийтлэгдэн гарсан тогтоолын дагуу нэг хүнийг тахин шүтэхийн хор уршгаар гэм буруугүй шийтгэгдэн хэлмэгдэгсдийг цагаатгалын ажлыг эрхэлэх Улс Төрийн Товчооны онцгой комиссыг эмхлэн байгуулжээ. Түүхчид өдөр тутмын хэвлэлүүд дээр түүхэн

²² Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг сайжруулах шинэ зорилт, Үнэн, 1988.11.16.

хүмүүсийн намтрын талаар материалууд хэвлэн нийтлүүлж, энэхүү мэтгэлцээнийг идэвхийлэн өрнүүлж эхэллээ. Түүхэн сэдвээр өрнөсөн энэхүү мэтгэлцээн нь нөгөө талаас он удаан жилээр дарлагдан цөхөрч байсан нийгмийн сэтгэлийн хөдөлгөөнийг тэсрээж орхисон байна. Өнгөц харахад эдгээр нийтлэлүүд нь 30-аад оны хэлмэгдүүлэлтийн асуудлыг хөндөж байгаа мэт боловч мөн чанартаа МАХН анх байгуулагдсанаасаа хойш хэн болж хувирсан болон түүний хязгааргүй эрх мэдлийг хөндсөн байлаа. Зөвлөлтийн эсрэг үзэл улам л хүчээ илрэх болов. МАХН өөрөө ч нийтийн шүүмжлэлд хүчтэй өртөж эхэллээ.

Эргэлт

ЗХУ болон европын бусад социалист оронд өрнөж байсан үйл явцыг ажиглан харснаар МАХН өөрийн намыг хэрхэн өөрчлөх талаар илүү эрчтэй сэтгэх шаардлагай тулгарав. МАХН-ын Улс Төрийн Товчоо намын мөрийн хөтөлбөрийг шинээр боловсруулах тогтоол батлан гаргав. Намын ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх өөрийн биеэр энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулах комиссыг даргалав. 1989 оны 2-р сарын 22-ны өдөр зохион байгуулсан энэ комиссын анхны хуралдаан дээр онцлон тэмдэглэхдээ: "МАХН-ын Программыг шинэчлэн найруулах комиссын ажлын зорилт, үндсэн зарчмыг тодорхойлж, Намын XV Бүгд хурлаар баталсан Программыг шинэчлэн найруулж, боловсруулахын тулд эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, намын ажилтан, улс ардын аж ахуйн соёлын салбарын төрөл бүрийн мэргэжлийн саналыг өргөн авч, өөрийн орны онцлог, шинэчлэл, өөрчлөлтийн шаардлагыг тусган, ардчиллыг хөгжүүлэх үзэл санааны үүднээс манай орны социалист байгуулалтын өнөөгийн төвшин, хэтийн төлөвийг шинжлэх ухааны онолын үндэслэлтэйгээр бодитой нягтлан дүгнэхийн чухал."²³

Өрнөж байгаа үйл явцыг ажиглан харахад Монгол оронд ч ялгаагүй улс төрийн гүнзгий өөрчлөлт гарах нь 1989 оны зун мэдэгдэхүйц болж ирсэн байдаг. МАХН-ын удирдлагыг засгийн газартай нь огцруулах шаардлагыг хүн ам, нийгмийн бүхий л давхаргын зүгээс улам хүчтэй тавих болов. Нийтээрээ МАХН-ын Төв Хорооны 5. Бүгд хурлаас тодорхой шийдвэр гарахыг хүлээж байлаа. Гэтэл энэ хурал хуучин загвараараа л ор нэр төдий болон өнгөрч, ямар ч халаа сэлгээ хийсэнгүй өнгөрөв. Намын удирдах нөхдүүд харин ч монголын Ардын хувьсгалын 70 жилийн ойн өмнө ямар ч өөрчлөлт, халаа сэлгээ хийхгүй болохоо мэдэгдсэн байна.²⁴ Харин хүн амын дунд энэ байдалд ерөнхийдээ дургүйцсэн, урам хугарсан уур амьсгал ноёрхов. Иргэдийн дунд МАХН-д итгэх

²³ Үнэн, 1989.02.23.

²⁴ Ч. Ганбат, Ардчиллын Хуанлигаас, Үнэн, 1992.11.09.

итгэл хүчтэйгээр ганхлаа. 1989 оны 10-р сарын эхээр ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх БНАГУ-д зочилж, улс тунхагласны 40 жилийн ойн ёслолын арга хэмжээнд уригдан оролцов. Тэрбээр тэнд өрнөж байсан бүхий л үйл явцыг өөрийн нүдээр ажиглан харж, монголын элчин сайдын түүнд өгч байсан мэдээлэлтэй өдөр тутам танилцаж байсан нь Ж. Батмөнхийн хувьд магад тун ч чухал улс төрийн мэдлэг туршлага болж өгсөн байх ёстой.

1989 оны 11-р сард МУИС-ын хэсэг оюутнууд “Хөвсгөл нуурыг хамгаалах хөдөлгөөн”-ийг үүсгэн байгуулав. Тэд Хөвсгөл нуураас холгүй фосфоритын ордыг ашиглах үйлдвэр байгуулах тухай мэдээллийг олж аваад энэхүү байгууламжаас учрах ёстой хэмжээлшгүй их хор хохирлыг тойрон гарахын төлөө анхнаасаа л түүнийг байгуулахгүй байх шийдвэр гаргахыг засгийн газраас шаарджээ. Засгийн газар энэхүү шаардлагыг хэргэжүүлсэн нь урд хожид засгийн газраа эсэргүүцэж байсан түүхгүй энэхүү улс оронд аж төрж байгаа залууст цоо шинэ сэтгэгдэл, өөртөө итгэх чадлыг өгсөн байна.

1989 оны 12-р сарын 11-ний өдрийн МАХН-ын Төв Хорооны VII. Бүгд Хурал дээр Улс Төрийн Товчооны гурван гишүүнийг огцруулж, удирдлагын төвшинд байсан өөр гишүүдийг тэдгээр албанд томилов. Намын Хянан Шалгах Хороо хэмээх МАХН-ын сахилгын хамгийн дээд шатны институцийн даргын албан тушаалд анх удаа Улс Төрийн Товчоогоор дамжаагүй гишүүнийг дэвшүүлэн тавив. Харин ард иргэд энэхүү өөрчлөлтийг ердөө л дүр үзүүлсэн нүүрний засал чимэглэл хэмээн үзлээ. Ингээд ард иргэд МАХН-ын Төв Хороо, Засгийн газраас намын удирдлагыг үг дуугүй огцрохыг улам хүчтэй шаардаж эхлэв.

1990 оны 1-р сарын 20-ны өдөр МАХН-ын удирдлага намынхаа статусыг шинээр тодорхойлсон төслийг хэвлэлээрээ нийтлүүлэн гаргав. Энэхүү төслөөс ч мөн адил тус намын удирдлага өөрийн хуучин зарчмуудаасаа огтхон ч ухрахгүй гэдэг нь илт ойлгогдов. Тэрбээр цаашдаа ч марксизм-ленинизмийн зарчимдаа үнэнч байж, Үндсэн хуулинд заасан удирдан чиглүүлэх үүргээ хэвээр нь авч үлднэ гэдэгтээ итгэл дүүрэн байлаа. Энэхүү төсөлд зааснаар бол МАХН цаашдаа ч Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл (МХЗЭ), ҮЭ болон бусад олон нийтийн байгууллагуудын хувьд бүхий л эрх мэдлийг нь гартаа атгасан хэвээр үлдэж, монголын ардын армийн доторхи бүтцээ ч мөн хуучин хэвээр нь авч үлдэхээр санагалзаж байлаа. Оруулсан өөрчлөлтүүд нь ердөө л хий хоосон сурталчилгаа болж таарав. Улс Төрийн Товчооны оронд Төв Хорооны Тэргүүлэгчдийн газар гэгчийг байгуулахаар төлөвлөсөн байна. Энэхүү газрыг ерөнхий нарийн бичгийн даргын оронд тэргүүн дарга ахлах ёстой ажээ.

МАХН-ын удирдлага энэхүү ор нэр төдий өөрчлөлтөөр ард иргэдийн нүдийг хуурч дөнгөнө гэж тооцоолсон нь ихээхэн том ташаарал болж хувирав. Энэхүү төсөл хэвлэгдэн гарсны маргааш МоАХ-ны санаачилгаар олон мянган хүмүүс Сүхбаатарын талбай дээр тухайн үед МАХН-ын удирдлагын байр байсан Засгийн газрын ордны өмнө цугларч, МАХН-ын бодлого, түүний засгийн газрын эсрэг жагсаал хийсэн байна. Энэхүү цуглаан нь МАХН-ын хувь хүнд цохилт болов. 1990 оны 2-р сарын 18-ны өдөр МоАХ-г албан ёсоор үндэслэн байгуулсан нь МАХН-ын Улс Төрийн Товчоог эрс алхам хийхээс аргагүй байдалд хүргэсэн юм. 2р сарын 2-нд улсын төв номын сангийн өмнөх Сталины хөшөөг буулгаж, 2-р сарын 28-нд МАХН-ын Онц Их Хурлыг зарлан хуралдуулах, мөн МАХН-ын ээлжит Их Хурлын хугацааг наашлуулсан болохоо зарлахаас өөр аргагүйд хүрчээ.

Энэ үеэр гудамжнаас учруулах дарамт улам хүчээ авлаа. 3-р сарын 7-ны өдөр сөрөг хүчний 10 гишүүн Сүхбаатарын талбай дээр өлсгөлөн зарлав. Улс Төрийн Товчооны ярилцлага дээр ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх (магад жилийн өмнө Зүүн Берлиний Ард түмний ордны өмнөх талбай дээр харсан зүйлээ эргэн санасан биз) өөрийнхээ ард түмний эсрэг цэрэг цагдаагийн хүч хэргэлэхгүй байх шийдвэр гаргалаа. Гэсэн хэдий ч байдал тийм ч тайван биш байв. Ийм учраас МАХН, МоАН, МСДН, МоАХ, Ардчилсан Социалист Хөдөлгөөн, Шинэ Дэвшлийн Холбоо болон Монголын Оюутны Холбооны төлөөлөгчдийн бүрэлдхүүн хэлэлцээр хийхээр Дугуй ширээний ярилцлагууд зохион байгууллаа. 1990 оны 3-р сарын 11-ний өдөр Дугуй ширээнд орологч талууд монголын олон нийтэд хандан мэдэгдэл гаргалаа. Үүнд:

„Энэ тунхаглалд нэгдэж байгаа улс төрийн нам, хүчнүүд нийгмийг ардчилах өөрчлөн байгуулалтын явцад эх орон, улс үндэснийхээ эв нэгдэл, эрх ашгийг эрхэмлэн дээдлэх үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлан түүнд нийцсэн үйл ажиллагаа явуулахаа ард түмэндээ зарлан мэдэгдэж, дараахь зүйлийг тунхаглаж байна.

Монгол Улсаа хөгжүүлэн мандуулж хүнлэг ардчилсан социалист нийгмийг хүн төрөлхтөний үнэт зүйлс, соёлт ертөнцийн нийтлэг туршлагад тулгуурлан, үндэснийхээ онцлогыг хадгалах замаар байгуулах явдлыг өөрсдийн үйл ажиллагааны үндсэн зорилго болгоно.

Тунхаглалд нэгдсэн талууд үйл ажиллагаа явуулахдаа хууль ёсыг эрхэмлэн дээдэлж, Монгол улсынхаа тусгаар тогтнол, үндэсний эрх ашигт ямар нэг хохирол учруулахгүй, ард иргэдийг албадан оролцуулахгүй, хөрш зэргэлдээ болон дэлхийн бусад улс оронтой энх тайвнаар зэрэгцэн оршиж, тэгш эрхийн үндсэн дээр харилцан ашигтай

хамтын ажиллагаа явуулах зарчим баримтална.

Улс төрийн үйл ажиллагаандаа тэгш эрхтэй байх, бие биенээ харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, нэг нэгнийхээ эсрэг хүч үл хэрэглэх зарчим баримтлах бөгөөд улс төрийн тулгамдсан асуудлаар харилцан зөвлөлдөж тохиролцоонд хүрэхийг эрмэлзэх болно.

Улс төрийн нам, хүчнүүдийн нийгмийн эрх ашгийг төлөөлөх чадвар нь төрийн байгууллагын шударга ардчилсан сонгуулийн дүнгээр тодорхойлогдоно.

Тунхаглалд нэгдэн орсон улс төрийн нам, хүчнүүд тулгамдсан асуудлыг өөрсдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн зөвлөлгөөнөөр хэлэлцэн шийдвэрлэж байна.

Энэ тунхаглалын үзэл санааг зөвшөөрч дэмжиж байгаа улс төрийн нам, хүчнүүдтэй хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж байна.”²⁵

Энэхүү мэдэгдлийн онцлог шинж чанар нь оролцогч талуудын хэн нь ч монголын социалист хөгжлийн замд эргэлзээгүй байсанд оршино. Энэхүү баримт бичиг олон нийтийг илтэд тайвшруулж чадав.

1990 оны 3-р сарын 12-ны өдөр МАХН-ын Төв Хорооны 8. Бүгд Хурал хуралдав. Хуралдааны эхний өдөр л Онц Их Хурал хуралдуулах талаар маргалдаж, Улс Төрийн Товчоо, Төв Хорооны нарийн бичгийн дарга нарыг чөлөөлөх шийдвэр гарлаа. БНМАУ-ын түүхэнд анх удаа хуралдааны илтгэлүүдийг радио, телевизээр нээлттэй шууд дамжуулав. Хурлын төлөөлөгчид өмнө нь намын дунд шатны удирдах ажилтан байсан Г.Очирбатыг МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар сонгов. 3-р сарын 31-ний өдөр МСДН үүсгэн байгуулах анхны хурлаа зарлан хуралдуулав. Сөрөг хүчний өөрийнх нь эгнээнд зүүний альтернатив хүчин байгуулагдсан нь МАХН-ын хувьд энэ хүнд хэцүү цаг үед үнэхээр том сорилт болох нь тэр.

МАХН-ын удирдах эгнээнд халаа сэлгээ хийснээр Монгол улсын төрд ч өөрчлөлт орууллаа. 3-р сарын 22-24-ний өдрүүдэд Ардын Их Хурал хуралдав. Хурлын төлөөлөгчид П. Очирбатыг (МАХН) АИХ-ын тэргүүлэгчдийн даргаар, түүнчлэн төрийн тэргүүнээр сонгов. Ш.Гунгаадоржийг (МАХН) БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргаар сонгов.

Онц Их Хурлын бэлтгэл ажлыг хариуцсан комисс 3-р сарын 27-ны

²⁵ Монголын ард түмний сонорт хүргэх улс төрийн тунхаглал, Үнэн, 1990.03.11.

өдөр БНМАУ-ын түр статусын талаар боловсруулсан төслөө хэвлэлээр олон нийтэд хүргэв. Энэ нь төсөл тун ч товч байсан нь өмнөхөөсөө эрс ялгагдаж байлаа. 1-р сард гарсан төсөлд МАХН-ын өөрийн дүр төрхийг илтгэх оршил хэсэг огт байгаагүй бол энэ удаа харин оршил хэсэгт нь: "... Монгол Ардын Хувьсгалт Нам бол хүнлэг ардчилсан социализмын үзэл санааг баримтлан монголын нийгмийг өөрчлөн шинэчлэхийн төлөө тэмцэгч улс төрийн байгууллага мөн. Ард түмний сайн сайхны төлөө тэмцэх нь МАХН-ын дээд зорилго болно. МАХН үйл ажиллагаандаа маркск-ленинч арга зүйг бүтээлчээр хэрэглэнэ."²⁶

МАХН энэ удаа хэдийгээр өөрийн үзэл суртлын үндэс язгуурыг нэрийдсэн хэдий ч "социализмыг бүрэн төгс байгуулна", эсвэл "социалист нийгэм" гэсэн санаанууд огтхон ч цухалзсангүй. 41р бүлэгт дурдагдсан нэн чухал зүйл бол: "МАХН үйл ажиллагаагаа БНМАУ-ын Үндсэн хуулийн хүрээнд явуулна."²⁷ Ингэснээр МАХН үндсэн хуулийн эрх зүйн хөрсөн дээр бууж ирсэн бөгөөд үндсэн хуулинд өөрчлөлт орсон тохиолдолд ч МАХН-ыг нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрүүлэх боломж олгох ёстой заалт ажээ.

42-р зүйлд МАХН-ыг сонгуулийн нам болгон бэлтгэх заалтыг оруулжээ. Үүнд: "Төрийн сонгуульд нам өөрийн хөтөлбөрөө боловсруулж оролцоно. МАХН төр, засгийн байгууллагад ажиллаж байгаа гишүүдээрээ дамжуулан улс төрийн бодлого, шийдвэрээ хэрэгжүүлнэ."²⁸ Монголын төрийг дангаар эзэгнэх гэсэн намын уламжлалыг шинэ үндсэн хуулинаас хассан бололтой. Гэхдээ энэхүү санаархал 46-р бүлэгт ахин цухалзсан байдаг. Тэрбээр МАХН-ын бүтцийг "БНМАУ-ын зэвсэгт хүчний доторхи намын байгууллагуудад" хэвээр хадгалан авч үлдэнэ хэмээн заасан байна. Энэхүү шинэ төслийн энэ заалтад МАХН-ын эрх мэдлийг 1-р сарын хувилбарт зааснаасаа илүү тэлж өгчээ. Учир нь түрүүний төсөлд зөвхөн БНМАУ-ын ардын арми дахь намын байгууллагууд хэмээн зааж өгсөн байсан. Шинэ төсөлд олон нийтийн байгууллагуудын хувьд МАХН-ын удирдан залуурдах үүргийг болиулсан байна. Харин түүний оронд "МАХН нь БНМАУ-ын үндсэн хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг, монголын төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн бүхий л улс төрийн намууд, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах"-ыг намынхаа улс төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон тунхаглажээ.

²⁶ Монгол Ардын Хувьсгалт Намын түр дүрэм, Үнэн, 1990.03.27.

²⁷ Мөн адил.

²⁸ Мөн адил.

МАХН-ын Онц Их Хурал

1990 оны 4-р сарын 10-13-ны өдрүүдэд МАХН-ын Онц Их Хурал хуралдав. Энэ нь МАХН-ын түүхэнд байсан анхны Онц Их Хурал юм. Тухайн түүхэн цаг үед үүссэн байсан, цаашдын чиг хандлагыг нь урьдчилан таамаглах аргагүй байсан тэрхүү давтагдашгүй нөхцөл байдал энэ хурлыг ийнхүү өндөр ач холбогдолтой болгож өгсөн байна.

Их Хурлын төлөөлөгчдийн өмнө намын цаашдын хувь заяаг тодорхойлох, цаашилбал монголын хөгжилд гүнзгий нөлөө үзүүлэхээр бэрх асуудлуудыг ярилцан хэлэлцэх ёстой байв. Үүний тулд нэг талаас улс орны дотоод бодлоготой холбоотой шинэ нөхцөл байдал, нөгөө талаас намын бүхий л үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх шаардлагатай боллоо. Энэхүү нөхцөл байдлын хажуугаар намаа сарнин бутрахаас хамгаалахуйц зөвшилцөлд хүрэх, намыг бодлогын ба материаллаг талаас нь авч үлдэх, мөн "олон намын нөхцөлд, эвсэл, холбоод, янз бүрийн хөдөлгөөний үүсгэл санаачилгын дунд"²⁹ МАХН-ын бодлогыг шинээр тодорхойлох шаардлагатай болжээ. Намын Онц Их Хурлын өмнөхөн намын удирдлага нэн хүчтэй дарамт шахалтын дор орлоо. Олон нийт ч энэхүү Их Хурлаас маш их зүйлийг хүсэн хүлээж байлаа. Тэр бүү хэл МАХН-ын суурь болох жирийн гишүүдийн зүгээс ч байнгын шахалт үзүүлж эхэлсэн байна.

Намын ерөнхий нарийн бичгийн дарга Г.Очирбатын тайлан илтгэлд дурдсанаар МАХН цаашид авч хэргэжүүлэх өөрийн бодлогод эргэлзэж тээнэгэлзсэн зүйл огтхон ч үгүй байгааг ойлгуулав. Тэрбээр хэлэхдээ: "... Шинэчлэгдсэн МАХН-ын дүр төрх гэвэл: БНМАУ-д ардчилсан социализм байгуулах үйлсэд хөдөлмөрчдийг нэгтгэн нягтруулах, ард түмнийхээ язгуур эрх ашгийг илэрхийлэн, түүний сайн сайхан аж байдлын төлөө мятаршгүй тэмцэж, сайн дураар эвлэлдэн нэгдсэн үзэл бодол, хүсэл зорилго нэгтэй ажилчин, малчин, сэхээтэн түмнийхээ эх оронч, интернационалч эвийн холбоог гагнан бэхжүүлэхийг зорьсон марксист-ленинист үзэл санаа, арга зүйг бүтээлчээр хөгжүүлэн хэрэгжүүлэх үзэл баримтлалтай улс төрийн байгууллага байх болно."³⁰ Г.Очирбатын тодорхойлсон шинэ зорилгод таарсан намын шинэ хөтөлбөр зайлшгүй шаардлагатай боллоо. Энэ утгаараа намын тав дахь мөрийн хөтөлбөр болон түүний шинэ байр суурийг батлан гаргасан явдал энэхүү Их Хурлын хамгийн чухал үр өгөөж болжээ.

²⁹ Онц Их Хурлын онцлог, Үнэн, 1990.03.28.

³⁰ Монгол Ардын Хувьсгалт Намын Онц Их Хурал, Өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлж МАХН-ыг шинэчлэх ойрын зорилт, МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Г.Очирбатын тавьсан илтгэл, Үнэн, 1990.03.28.

Энэхүү хоёр баримт бичиг нь нам өөрийгээ энэ мөчид хэрхэн үнэлж дүгнэж байсан талаар нэлээд ойлголт өгнө. Намын мөрийн шинэ хөтөлбөрт: "... Монгол Ардын Хувьсгалт Намын эрхэм дээд зорилго бол монголын ард түмний язгуур эрх ашгийг хамгаалах явдал бөгөөд ард иргэн бүрийн чөлөөтэй хөгжих, сайн сайхан амьдрах, эрх тэгш байх боломжийг баталгаажуулсан, хүнлэг ардчилсан социалист нийгэм байгуулахад оршино."³¹ Өмнө нь боловсруулсан мөрийн хөтөлбөрийн төслөөс ялгагдах, намын шинэчлэгдсэн дүр төрхийг илтгэх зүйл бол 41-р бүлэгт заасанчлан МАХН өөрийн үйл ажиллагааг "БНМАУ-ын Үндсэн хууль болон төрийн бусад хуулийн хүрээнд" явуулахаар зохицуулсан явдал байлаа. Төслийн 42-р бүлэгт намыг "төрийн сонгуульд нам өөрийн хөтөлбөрөө боловсруулж оролцоно" гэсэн бол одоо "төрийн сонгуульд улс төрийн тэргүүлэх байр суурь эзлэхийн төлөө нам тууштай тэмцэнэ"³² хэмээсэн байна. Уг нь намын бодлогыг хэргэжүүлэх талаар: "МАХН өөрийн бодлого шийдвэрээ төр засгийн албанд ажиллаж байгаа өөрийн гишүүдээр дамжуулан хэргэжүүлнэ" хэмээн оруулсан байсан. Гэтэл намын жинхэнэ мөрийн хөтөлбөрт эдийн засгийн ба олон нийтийн байгууллагууд болон дэлгэрүүлсэн байна. МАХН цаашдаа ч өөрийн намын байгууллагуудыг "БНМАУ-ын зэвсэгт хүчний байгууллагуудын бүтцэд" хэвээр үлдээхээр заажээ. Намын Төв Хорооны Анхдугаар хуралдаанаар 4-р сарын 13-ны өдөр Төв Хорооны тэргүүлэгчдийн бүрэлдхүүнд ерөнхий нарийн бичгийн дарга Г. Очирбатаас гадна өмнө нь намын удирдлагын дунд шатны бүрэлдхүүн багтаж байсан хэдэн хүн сонгогдон орсон байдаг. Нэрт зохиолч Л.Түдэв намын хэвлэлийг удирдах боллоо. Тухайн үеийн тэргүүлэгчдийн газрын бүрэлдхүүнийг ажиглахад намын шинэ удирдлагын гишүүд нь зөвхөн түр зуурын шилжилтийн үеийн шийдэл болох нь ойлгогдоно.

Дараачийн үе шатнаас эхлэн МАХН-ын удирдлага бүтцийн болон боловсон хүчний гүнзгий өөрчлөлтүүд хийж эхлэв. Тэргүүлэгчдийн газрын шийдвэрээр намын Төв Хорооны аппаратын бүтцийг өөрчлөв. Өмнө нь байсан найман хэлтэс (+ нэг тасаг)- ийн оронд нийгэм ба эдийн засгийн бодлогын, намын байгууллагуудын, онол ба үзэл суртлын хэлтэсүүд, түүнээс гадна тамгын газрыг байгууллаа. Намын аппаратын бүрэлдхүүнийг 44%-иар цомхотгов. Энэхүү цомхотголд үндсэндээ намын Төв Хорооны хуучин гишүүд хамрагдсан байна. Намын Онц Их Хурлаас батлан гаргасан намын шинэ чиг баримтлалын дагуу намын бүхий л шатны байгууллагуудын удирдлагыг шинээр сонгох сонгууль явагдлаа. Энэ бүхний үр дүнд боловсон хүчний маш нүсэр өөрчлөлт хийгджээ:

³¹ Монгол Ардын Хувьсгалт Намын мөрийн хөтөлбөр, Үнэн, 1990.04.17.

³² МАХН-ын Онц Их Хурал, УБ 1990, 37-р тал.

аймаг, хотын намын хорооны удирдлагуудын 72,3%, дүүргийн намын хорооны удирдлагуудын 62% нь анх удаа шат ахин, шинээр сонгогдон гарч ирлээ.³³

Парламент 11 дэх удаагийн сонгуулийнхаа хугацааны дотор 1990 оны 5 сарын 10-ны өдрийн хуралдаанаар "Улс төрийн намуудын тухай Монгол Улсын хууль"-ийг батлан гаргав. Хууль хүчин төгөлдөр болсноос хоёр цагийн дараа ерөнхий нарийн бичгийн дарга Г.Очирбат МАХН-ыг Улсын Дээд Шүүхэд бүртгүүлээ. Намаа бүртгүүлэх хүсэлтэд: "МАХН эрх баригч намын хувьд төрийнхөө хуулийг хүндэтгэн дээдлэх зарчмыг иш үндэс үндэс болгож, 1921 оны гуравдугаар сарын нэгэнд байгуулагдсан тэр өдрөөсөө албан ёсоор бүртгүүлэх нь зүйтэй гэж үзэж байна."³⁴ Бусад улс төрийн хүчнүүдэд "МАХН" болон "Монгол Ардын Нам" хэмээх нэрийг авч хэрэглэхийг МАХН хориглосон байна. Энэхүү шаардлага нь ялангуяа өөрийн намын дотор жигүүр байгуулан тэмцэгчдийн эсрэг чиглэгдсэн санааг агуулсан байв. Намын зарим гишүүд хуучин МАН ба түүний анхны уламжлалыг сэргээх санал дэвүүлжээ. Үнэн сонин дээр МАН-ын дүрэм, мөрийн хөтөлбөрийг хэвлэн гаргав. Харин хэрхэх яах санаатай байгаа нь ойлгогдохгүй мэдэгдэхгүй байлаа. Хуучин уламжлалаа эргээн сэргээснээр марксизм-ленинизмын үзэл баримтлалаасаа хөндийрч, өнгөрсөн түүхэнд МАХН-ын хийсэн алдаа завхарлаас салах боломжийг олгох байлаа.

1990 оны эхэн үед Намын Төв Хороо удирдагчдынхаа эдэлж байсан тусгай хангамжийн систем, хөнгөлөлтүүдийг хүчингүй болгов.

Намын Онц Их Хурлаас Ю.Цэдэнбал болон нам засгийн удирдагчдын (Улс Төрийн Товчооны жинхэнэ ба орлогч гишүүд, Төв Хорооны нарийн бичгийн дарга нар, Сайд нарын зөвлөлийн гишүүд) үйл ажиллагааг үнэлж дүгнэх үүрэгтэй хороог байгуулах шийдвэр гаргав. Энэхүү хороо өөрийн ажлын тайланг 6-р сарын 29-ний өдрийн МАХН-ын Төв Хорооны 3. Бүгд Хурал дээр танилцуулав. Судалгаанаас гарсан үр дүн дээр үндэслэн гаргасан шийдвэртээ дараахь саналыг оруулжээ: намын удирдлагад байсан Д.Моломжамц, Т.Рагчаа, Д.Майдар, С.Лувсан, Д.Гомбожав, Н.Лувсанравдан, Б.Дэжид, Б.Ламжав нарыг намын гишүүнээс хасаж, Ж.Батмөнх, Д.Содном, Б.Алтангэрэл, С.Лувсангомбо, Б.Лхамсүрэн, Д.Чимиддорж, С.Сосорбарам, Г.Адьяа, П.Дамдин, Ц.Намсрай, Д.Цэвэгмид, М.Пэлжээ, М.Даш, Ч.Сүрэн нарыг намын гишүүнээс хасах сануулга өгөн донгодсон байна.³⁵ Харин намын

³³ Намын анхан шатны болон аймаг, хотын намын байгууллагын сонгууль явуулах журам, Үнэн, 1990.05.08.

³⁴ МАХН-ын Төв Хорооны дарга өргөдөл гаргав, Үнэн, 1990.05.11.

³⁵ МАХН-ын Төв Хорооны 3-р Бүгд Хурлын тухай сонсгол мэдээ, Үнэн, 1990.06.30.

Төв Хорооны 3. Бүгд Хурал энэ хорооны гаргасан саналаас заримыг нь л хүлээн авч хэргэжүүлсэн байдаг.³⁶

Энэ оны 6-р сард намын төв хянан шалгах хорооноос намыг өөрөө өөрийг нь санхүүжүүлдэг чадвартай болгох талаар шийдвэр гаргав. Энэхүү шийдвэр нь нэн чухал алхам байсан болсны учир нь: 1. намыг цаашид санхүүжүүлэхийг зогсоох болсон, 2. МАХН ингэснээрээ эртнээс намын өмчийн асуудлаа баталгаажуулах ажил хийх ёстой болсон байжээ.

Анхны чөлөөт сонгууль

БНМАУ-ын парламент болох АИХ-аас 1990.07.22-ны өдөр орон нутгийн ард түмний элч нарыг сонгох, 1990.08.26-ны өдөр АИХ-ын сонгуулийг тус тус явуулахаар шийдвэрлэв. МАХН энэ сонгуульд маш хичээнгүйлэн бэлдлээ. Тэрбээр сонгогчидод намын агуулга ба боловсон хүчний бодлого гүнзгий өөрчлөгдсөн хэмээн ойлгуулахаар чармайж байлаа. Дарамт шахалтын дор энэхүү өөрчлөлтүүдийг хийсэн явдал, сонгогчидод намыг үндсээрээ өөрчлөгдсөн хэмээн итгэл үнэмшил төрүүлэх шаардлага, өөрөөр хэлбэл улам бүр өөртөө итгэлтэй болж байгаа сөрөг хүчний шаардлагад хариу барих зэрэг нь энэ бүх бодлогын зоосны нөгөө тал нь байсан юм. Зөвхөн 5-р сард гэхэд “Лус төрийн намуудын тухай хууль”-ийн дагуу Монголын Үндэсний Дэвшлийн Нам (МҮДН), Чөлөөт Хөдөлмөрийн Нам (МЧХН), Монголын Ардчилсан Нам (МАН), Монголын Социалдемократ Нам (МСДН), Монголын Ногоонтны Нам (МНН) МУ-ын Дээд Шүүхэд улс төрийн нам болон албан ёсоор бүртгүүлцгээв. Эдгээр шинэ намуудыг ялангуяа залуу үеийнхэн болон сэхээтнүүд ихэд талархан дэмжиж, хот хөдөөгүй олон тооны дэмжигчидтэй болж байлаа. Ялангуяа МАН, МҮДН, МСДН-ийг илүүтэй дэмжив. Энэ нь тэдгээр намууд нийгмийг шинэчлэх шаардлагаа эрс тод, нэлээд шаргуу тавьж байснаас дан ганц шалтгаалсангүй, мөн эдгээр намуудад сонирхол татахаар содон хүмүүсээрээ дэмжигчдээ байлдан дагуулж чадсан юм. МАХН-ын сонгуульд “Шинэчлэгдэж байгаа Монгол Ардын Хувьсгалт Намын төлөө саналаа өгцгөөе! МАХН-ын эрхэм дээд зорилго: Эх орон, ард түмний язгуур эрх ашиг, эв нэгдэл; Иргэн

³⁶ МАХН-ын Төв Хорооны 3. Бүгд Хурлын шийдвэр: намын гишүүнээс хасах: Д.Гомбожав, С.Лувсан, Д.Майдар, Д.Моломжамц, Т.Рагчаа, Б.Дэжид, Б.Лхамжав, Гишүүнчлэлийг хэвээр үлдээсэн: Н.Лувсанравдан, намаас хөөхөөр донгодон сануулсан: Ж.Батмөнх, Д.Содном, Б.Алтангэрэл, С.Лувсангомбо, Г.Адьяа, П.Дамдин, намаас шийтгэл оногдуулахаас татгалзсан: Б.Лхамсүрэн, Д.Чимиддорж, С.Сосорбарам, Ц.Намсрай, Д.Цэвэгмид, М.Пэлжээ, М.Даш, Ш.Сүрэн

бүрийн чөлөөт хөгжил, сайн сайхан амьдрал; Ардчилал, тэгш эрх, шударга ёс." хэмээх уриа лоозонгоор оролцов. Эдгээр уриаг тэд маш ул суурьтай нягтлан сонгож авсан байна. Эдгээр нь сонгогчдын сэтгэлд намыг шинэчлэх арга хэмжээнүүд нь нийгмийн шинэчлэлийн зөвхөн эхлэл бөгөөд энэ нь цаашдаа тасралтгүй үргэлжлэх нь гэсэн ойлголт гөрүүлэх ёстой байлаа. МАХН өөрийгөө маш далайцтай өөрчлөгдсөн хэмээн үзэж байв. Тэрбээр 1960 онд Үндсэн хуулиар баталгаажуулсан удирдан чиглүүлэх үүргээсээ татгалзаж, хуучинсаг үзэл, хүнд суртал, захиргаадлын эдийн засгаасаа (ядахдаа л аман дээрээ) салж буйгаа илэрхийллээ. МАХН сонгуулийн сурталчилгаандаа бүхий л арга хэрэгслээ дайчлан хөдлөв. Тухайн үедээ монголын хэвлэл мэдээллийн салбарт монополь эрхтэй байсан МАХН-ын сонин хэвлэл дээр тогтоол шийдвэр, тунхаглал, ард түмэнд хандсан уриа лоозонг хэвлэн нийтэлж байжээ. 1990.7.1-ний өдрөөс ардчилсан төв хэвлэл "Ардын эрх" сонин анх хэвлэгдэн гарснаар улс төрийн бусад намуудад ч мөн үгээ хэлэх боломж олгосон нь МАХН-нд нэлээд таатай нөхцлийг бүрдүүлсэн байна. МАХН өөрийгээ нийт ард түмний сонирхлыг илэрхийлэгч нам хэмээн байнга сурталчилсаар байв. Үүний зэрэгцээ МАХН нь залуу үеийнхэн, сэхээтнүүд, ажилчин, малчдад тус бүрт нь таарсан сонгуулийн сурталчилгааны ялгавартай хэлбэрүүдийг өрнүүлсэн ажээ. Малчин, албан хаагчдын хувьд МАХН санаа зовохгүй байсан бөгөөд хамаг анхаарлаа залуучууд, сэхээтнүүд, ажилчдын зүгт хандуулав. Өөрөөр хэлбэл сөрөг хүчнийг маргаангүй сонгох "халуун цэг"-ийн тойргууд дахь эргэлзээтэй сонгогчид руу хамаг хүч чадлаа дайчлахаар тооцоолсон байна. Хэдийгээр аж үйлдвэрийн салбар нь монголын эдийн засагт харьцангуй чухал байр суурь эзэлж амжсан хэдий ч АИХ-д ажилчдын эгнээнээс нэр дэвшигчдийн тоо харьцангуй цөөн (799 нэр дэвшигчийн 18 нь ажилчид) байгааг МАХН сонгогчдод анхааруулаад ажилчдын эгнээнээс илүү олон хүнийг дэвшүүлэхийг уриалан дуудаж, өөрийн намын нэр дээр ажилчдыг олноор нь нэр дэвшүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсээр байв.

МАХН сонгуулийн дүнд хүссэн үр дүндээ хүрч чадав (намын өнгөрсөн түүх ба шилжилтийн цаг үеийн байдалтай харьцуулан үзэх хэрэгтэй). Орон нутгийн төлөөллийг сонгоход 53,4%, АИХ-ийн сонгох сонгуулиар нийт 84,8%-ийн саналыг авчээ. Ингээд МАХН Монгол Улсын парламентийн нийт 422 суудлаас 357 нь МАХН-д очсон байна. Монгол улсын түүхэнд анх удаагаа өөр намын гишүүд сонгогдон орлоо (МАН 16, МҮДН 6, МСДН 4). Парламентийн үлдсэн суудлыг гишүүн бусчууд, залуучуудын холбооны нэр дэвшигчид авсан байна. Ерөнхийдээ сөрөг хүчнийхэн чамлахааргүй амжилт үзүүлсэн билээ.

Сонгуулийн дүн (саналын %-иар)

МАХН	МҮДН	МЧХН	МАН	МСДН	МНН
61,74	5,95	1,22	24,33	5,52	1,24

МАХН ялалт байгуулснаар иргэдийн итгэлийг тодорхой хэмжээгээр эргүүлэн авч, нам нь өөрөө тогтворжих боломжтой боллоо. Сонгуулийн дараахан Улаанбаатар хотод иргэдээс авсан санал асуулгын дүнгээс харахад асуулгад орлцогчдын 56,5% нь МАХН "шинэчлэлийг хийж чадах улс төрийн хүчин (төр засгийн хүчин гэсэн санаа, зохиогч) мөн" хэмээн үнэлжээ. Хамгийн хачирхалтай нь ялангуяа дунд насныхан (39-49 насныхан) МАХН-ыг дэмжсэн байна. МАХН-ын сонгуулийн амжилт мөн энэ нам эргээд тогтвортой байдалд ороход эерэг нөлөө үзүүлсэн болно. Намын гишүүдийн тоо сонгуулийн дараа 1.734-өөр нэмэгдэж 100.049 болон өсөв. Харин намаас гарсан гишүүдийн тоо үүнтэй харьцуулахад харьцангуй бага байв.

Шинэ эхлэл

1990 оны 9-р сарын 3-ны өдөр АИХ-аас П.Очирбатыг Монгол Улсын анхны Ерөнхийлөгчээр сонгов. Түүний дараахан 9-р сарын 10-ны өдөр Д.Бямбасүрэнг (МАХН) Монгол Улсын ерөнхий сайдаар томилов.

МАХН ахин засгийн эрхэнд гарсан боловч нөхцөл байдал үндсэндээ өөрчлөгдсөн цаг үе ирсэн байлаа. Нэн тэргүүнд өөрчлөгдсөн үйл бол социалист монголын арын түшиг тулгуур болж байсан европын социалист улс орнууд ба ЗСБНХУ бутран сарнижээ. Тус улс анх удаа бие даах ёстой цаг үе ирэв. Энэхүү бодит байдал, дээр нь улс орны дотоод дахь тулгамдсан асуудлуудын давалгаан шилжилтийн анхны засгийн газрыг хүчирч дийлшгүй нөхцөл байдал руу хөтлөн оруулсан байна. Иймээс "МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиг баримжаа"-г боловсруулсан нь зөвхөн асуудлын хариултыг олоход туслаад зогсохгүй ирээдүй рүү хандсан, монголын нийгмийн шинэчлэлтийн хувь заяатай шууд холбоотой шийдвэрүүд гаргах чухал баримт бичиг болж өгсөн юм. Засгийн газар энэхүү баримт бичигт онцлон тэмдэглэхдээ түүхийн нөхцөл байдлын онцлог нь "Нийгмийн амьдралын зохион байгуулалтын хуучин хэлбэр үеэ өнгөрөөж байсан боловч хөгжлийн шинэ хэвшил төлөвшөөгүй, нийгмийн харилцааны шинэ тогтолцоо бүрдээгүй байгаа ..." явдал гэж тэмдэглэжээ.³⁷ Засгийн газрын үзэж байгаагаар өнгөрсөн хугацаанд "... эдийн засгийн зохицуулалтын

³⁷ БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, Үнэн, 1991.01.03.

хуучин тогтолцоо нь ардчиллаар сэргэсэн нийгмийн шинэ ухамсартай зөрчилдөж" байлаа.³⁸ Энэхүү хямралаас гарах цор ганц арга зам бол нийгмийн амьдрал нь зах зээлийн зарчим дээр тулгуурласан Монгол орныг "эргэж төрүүлэх" явдал. Үүнтэй холбоотойгоор монголын Засгийн газраас монголын нийгэм дэх өмчийн харилцааг өөрчлөх явдал хэмээн үзлээ. Өөрөөр хэлбэл улсын өмчийг хувьчлах яригдаж байгаа хэрэг бөгөөд энэ алхмыг хэргэжүүлэхэд дараахь зарчмыг баримтлах ёстой: "Төрийн өмчийг хувьчилж авах эрх бүхий субъект нь Монголын ард түмэн гэж үзнэ."³⁹

Монгол оронд зах зээлийн харилцааг бий болгосноор урьдчилан таамаглах аргагүй нийгмийн үр дагавар үүсэн бий болохыг тухайн цаг үеийн нөхцөл байдал илэрхий хэлээд байлаа. Гэвч Засгийн газарт өөр гарц байсангүй. Аж үйлдвэр, хөдөө аж ахуйн амин чухал салбаруудын үйлдвэрлэл огцом буурав. Улсын нөөц шавхагдах дөхлөө. Хуучин цагт гэтэл ЗХУ, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын утсламжинд найдах боломжтой байжээ. Хүмүүсийн итгэл найдвар алдарч эхэллээ. Хаашдаа л ажилдаа хандах хойрго хандлага газар авсан байлаа. Төлөвлөгөөний сахилга бат, гэрээнд үнэнч байх явдалд улам бүр эргэлзээтэй болж ирлээ. Монголчуудын сэтгэлгээнд анархи, эмх замбараагүй байдал газар авлаа. Ардчилал гэдгийг дуртайгаа хийж, дургүйгээ хаяж болох дур зоргын үзэгдэл хэмээн ойлгож авлаа. "Зах зээл" хэмээх ойлгомжгүй нэр томъёотой мөн тулгарлаа. Энэ нэр томъёоны агуулгыг социалист үйлдвэрлэлийн харилцааг гүйцэтгэсэн ажлынх нь хэмжээгээр урамшуулж, илүү үр ашигтай хөдөлмөрлөх хэмээн тайлбарлав. "Зах зээл", "капитализм" хэмээх хоёр нэр томъёог эн тэнцүү утгаар хэрэглэхээс татгалзав.

Засгийн газар зах зээлийн харилцааг бий болгох замдаа хэдийгээр олон алдаа мадаг гаргасан ч хүлээн зөвшөөрөх ёстой нэг зүйл бол тэд энэ замыг эргэж буцалтгүй сонгосон явдал. Тэдэнд энэ талын мэдлэг ихээхэн дутагдаж байсан, мөн өдөр тутмын аар саар ажил Засгийн газрын үйл ажиллагаанд тээг садаа болж байсныг мөн мартаж болохгүй. Парламент, Засгийн газрын нэн тэргүүний хийж гүйцэтгэх ёстой байсан бодлогын асуудал нь зах зээлийн эдийн засаг хөгжих хууль зүйн таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, эрх зүйн баталгааг бий болгох явдал байлаа. Энэ утгаараа хууль боловсруулах нүсэр аяныг эхлүүлсэн юм. Эдгээрээс онцгой ач холбогдол бүхий нь 1991 оны 5-р сарын 31-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн "БНМАУ-ын өмч хөрөнгийг хувьчлах тухай хууль" билээ.

³⁸ Мөн адил.

³⁹ Мөн адил.

Засгийн газар энэ бүхний хажуугаар олон улсын байгууллагууд, бусад гадаад орнуудаас тусламж олж авахыг эрмэлзэж байв. Энэ зорилгын дагуу Монгол Улс нь 1991 оны 1-р сар гэхэд ОУВС, Сэргээн Босголт, Хөгжлийн Олон Улсын Банкны гишүүн орноор элсэн орсон юм. Монгол улсад Япон орон онцгой тусламж дэмжлэг үзүүлэв. Ерөнхий сайд Т.Кайфу 1990, 1991 онуудад АНУ-ын Юистен хот болон Лондонд болсон "Их долоо"-гийн уулзалт дээр Монголын асуудлын тухай дэлгэрэнгүй ярьж, Монголын төлөө эдийн засгийн тусламж үзүүлэхийг дээр орнуудаас гуйсан байна.⁴⁰

Гарааны цэг рүүгээ эргэв

Нийгмийн маш хурдацтай өрнөж буй өөрчлөлт хөгжилтийн улмаас өөрийн эмхлэн байгуулсан Засгийн газрынхаа бодлогыг ойлгохгүй хоцрогдох аюул МАХН-ын өмнө тулгарав. Гэхдээ зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхтэй уялдуулан гаргаж байгаа шийдвэрүүд энэ намын баталсан Монгол орны "ардчилсан, социалист хөгжлийн зам" хэмээх томъёоллоор эхэлсэн мөрийнх нь хөтөлбөрт орсон үг өгүүлбэртэй бараг л дүйцэж байлаа. Дээр дурдсан бэрхшээлээс гадна МАХН-ын хувьд зах зээлийн баримжаанаас үүссэн үр дагавар түүний улс төрийн талаархи өөрийн төсөөлөлтэй нь огтхон ч таарч тохирохгүй болж ирэв. Олон тооны хүмүүс ажилгүй болж ядуурлын эгнээнд шилжив. 1994 оны нэгэн судалгаагаар 1991 он гэхэд 63.942 өрх ядуу буюу нэн ядуугийн эгнээнд орсон байв (түүнээс өмнөх баримт байхгүй). Эдгээр өрхөд нийт 320.513 хүн тоологддог нь нийт 2.149.000 хүн амтай Монгол орны хувьд бага биш тоон үзүүлэлт (1990 оны байдлаар). Иргэд тэр үеийн Засгийн газрыг МАХН-ын Засгийн газар хэмээн үзэж байсан тул нийгмийн бодит байдлыг МАХН-ын сонгуулийн амлалт, намынх нь мөрийн хөтөлбөртэй нь харьцуулан үзсээр байлаа. МАХН энэ хугацаанд Монгол орон цаашдаа социалист хөгжлийн замаар явах боломжгүй, 1990 онд үүсэн улс төрийн нөхцөл байдал нь эргэлт буцалтгүй болохыг ойлгож мэдсэн байлаа. МАХН-ын удирдлага намынхаа бодлогыг зах зээл рүү чиглүүлэн, өөрийн мөрийн хөтөлбөртөө өөрчлөлт оруулах талаар эргэцүүлж эхлэв. 1990 оны 11-р сард МАХН-ын Төв Хороо өөрийн намын 5. Бүгд Хурлын бэлтгэл ажилдаа орж, улс орныг зах зээлийн харилцаа руу оруулах удирдамж боловсруулахаар шийдвэр гаргасан байна.

⁴⁰ U. B. Barkmann, *Zu den japanisch-mongolischen Beziehungen der letzten Jahre, Asien – Deutsche Zeitschrift fuer Politik, Wirtschaft und Kultur* 1(1994), 30-44-р тал.

МАХН-ын Төв Хорооны 5. Бүгд Хурал (1990.05.20-22) намын бодлогод өөрчлөлт оруулав. Ерөнхий нарийн бичгийн дарга Г. Очирбат өөрийн тайлан илтгэлдээ зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг Засгийн газар ба ард түмний хяналтын дор хэргэжүүлэх ёстой, ингээгүй тохиолдолд сүүдрийн эдийн засгийг хөхүүлэн дэмжих боломж нээлттэй болохыг анхааруулан шаардлаа. Тухайн цаг мөчид шаардлагатай байгаа асуудлуудын тоонд: "Эдийн засгийг зах зээлд шилжүүлэх үүднээс эхний шатанд өмчийн харилцааг шинэчилж, түүний чөлөөт хөгжлийг хангах нөхцөл бүрдүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, өмч эзэн хоёрыг ойртуулж, улсын өмчийг эзэнтэй болгох нь маш чухал асуудал юм."⁴¹ Нийгэмд эзлэх намын байр суурь цаашдаа ямар байх талаар Г.Очирбат илтгэлдээ дурдахдаа шинээр бий болсон улс төрийн системийн агуулга, хэлбэрт зохицуулан МАХН ч бас бодлогоо өөрчлөх ёстой гэжээ. Г.Очирбат "улс төрийн систем дэх нэг намын Засгийн газрын байр суурь, эрх, үүрэг"-ийг илүү тодорхой болгох ёстой гэж үзсэн байна. Мөн тэрбээр "Намын Онц Их Хурлаар батласан МАХН-ын Мөрийн хөтөлбөр, Дүрмийн зарим үндэслэлийг орчин үеийн онолын сэтгэлгээний хөгжил хурдан өөрчлөгдөж байгааг" ч тэмдэглэв.⁴² Үүнийг тайлбарлахын тулд намын түүхийн хуудсыг эргээн сөхсөн байна. "МАХН үүсч бүрэлдэхдээ үндэсний ардчилсан зүүний нам байлаа. 70 жилийн хөгжлийг туулж, улс орныг удирдан жолоодох явцдаа манай нам гадаад, дотоод объектив нөхцөл, субъектив хүчин зүйлийн эрхээр үзэл баримтлал, бүтэц, үүрэг зорилгоо огцом өөрчилж, нийгмийн бодит хөрс сууринаас тасрах, улмаар коммунист хэв маягийн намд хамаарах хүртэл зохиомол өөрчлөлтөд орж байв. Энэ нь улс орныхоо бодитой нөхцөл байдлыг харгалзахгүйгээр бусад орны нийгмийн хэв загвар, сэтгэлгээний догматик аргыг намын үзэл сачаа, үйл ажиллагаанд механикаар тулган нэвтрүүлэх гэсэн сталинч арга барилтай юуны өмнө холбогдоно."⁴³

МАХН өнөөдөр Монгол улсын хөдөлмөрчдийн ашиг сонирхлыг төлөөлж байгаа ба "шинэ агуулга, шинэ чанартай болгон баяжуулсан" социалист сэтгэлгээнээсээ салахгүй барьж байх ёстойг Г.Очирбат онцлон тэмдэглэв.

МАХН өөрийн түүхийн нэгээхэн цаг үеэсээ тасран салж, анх

⁴¹ Улс орны цаг үеийн байдал, МАХН-ын байгууллагуудын хойшлуулушгүй зорилт, Үнэн, 1990.11.21

⁴² Мөн адил

⁴³ Мөн адил

үүсэж байсан үеийнхээ зүүний чиг баримжаатай ардын нам болох зам руугаа эргэн орохыг хүсэж байх шиг. Энэ намын өдөр тутмын үйл ажиллагаанаас ч энэ хандлагаа үнэхээр биелүүлэхээр шулуудсан нь ажиглагдаж байв. 5. Бүгд Хурлаас МАХН-ын XX Их Хурлыг 1991 оны 2-р сард товлон хуралдуулахаар товлон. Б.Даш-Ёндон, Н.Багабанди нарыг МАХН-ын тэргүүлэх гишүүдээр сонгосноор намын залуу үеийн шинэчлэлийн талын улс төрчид намн удирдлагын хүрээлэл рүү орж ирлээ. Эдгээр бүлгийнхэн намын цаашдын дүр төрхийг илэрхийлсэн билээ.

Намын Төв Хорооны 5. Бүгд Хурал дээр МАХН-ын улс төрийн байр суурь, өөрийн дүр зургийн тухай мэтгэлцээнийг МАХН-ын XX Их Хурал дээр (1991.02.25 - 28) ч үргэлжлүүлэн хэлэлцэв. Намын их хурлаас намын шинэ байр суурийг мөрийн хөтөлбөрт оруулах сонирхолтой байлаа. Энэ их хурлаас дүрмэнд өөрчлөлт болгон оруулахаар зорьж байсан шинэ заалт бол намын дотоод амьдралыг ардчилах асуудал байлаа. МАХН-ын түүхэнд анх удаа намын дотор олон жигүүр байж болохыг зөвшөөрөв. Гэхдээ мэдээж “намын дүрэм, мөрийн хөтөлбөртэй нийцэж байгаа тохиолдолд” энэ нь боломжтой ажээ. Энэ дүрмийн дагуу намын доторхи “МАН-ын уламжлал, шинэчлэлийн төлөө” жигүүр, “Ажилчдын жигүүр” хоёр нь хүлээн зөвшөөрөгдлөө. Энэ бол нэн чухал харилцан буулт болж өгсөн ба ингэсний хүчээр нам сарнин бутраагүй үлдсэн байна. Намын зургаа дахь мөрийн хөтөлбөрт намын өөрийн дүр зургийг ингэж оруулжээ: “МАХН шинж чанарын хувьд хүн төрөлхтөний нийгмийн тэргүүний сэтгэлгээний чухал ололт болсон социалист үзэл санааг баримталсан ардын ардчилсан нам мөн. Нам хөдөлмөрчин ардын язгуур эрх ашгийг илэрхийлэн хамгаална.”⁴⁴

МАХН-ын XXI их хурлаас (1992.02.26–28) батлан гаргасан намын долоо дахь мөрийн хөтөлбөрт намын өөрийн тухай дүр зураг мөн л өөрчлөгдөв. Энэ нам өөрийгээ “үндэсний ардчилсан нам” хэмээн үзэх болсон байлаа. Социалист үзэл баримтлалаас ул мөр ч үлдээсэнгүй. Намын мөрийн хөтөлбөрт харин ч “Монгол Ардын Хувьсгалт Нам бол ард түмнийхээ язгуур эрх ашгийг илэрхийлэн хамгаалж, үндэсний эв нэгдэл, нийгмийн дэвшлийг хангах зорилго эрмэлзлэл бүхий үндэсний ардчилсан шинжтэй улс төрийн байгууллага мөн.”⁴⁵

МАХН эргэж буцалтгүй шийдлээ. Тэрбээр өөрийн түүхийн нэг

⁴⁴ Монгол Ардын Хувьсгалт Намын мөрийн хөтөлбөр, Үнэн, 1991.03.05

⁴⁵ Монгол Ардын Хувьсгалт Намын дүрэм, Үнэн, 1992.03.05

үе шатнаасаа салж өөрийн улс төрийн дүр зургаа эрс өөрчиллөө. Энэ утгаараа МАХН өөрийнхээ түүхэн эхлэлийнхээ цэг рүү эргэн ирсэн гэж үзэж болно. Монголын сонгогчдын хувьд энэ намын хувьсал өөрчлөлт үнэхээр итгэл үнэмшил төрүүлмээр санагдсан бололтой. Ингээд МАХН 1992 оны 6-р сарын 28-ны өдөр болсон УИХ-ын сонгуульд үнэмлэхүй ялалтыг байгуулав. Энэ намаас нэр дэвшигчид парламентийн 76 суудлаас 70-ийг нь дангаараа авч чадлаа.